



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
СУДАЛГААНЫ ИНСТИТУТ

THE RESEARCH INSTITUTE OF LABOUR AND SOCIAL PROTECTION

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ҮЗҮҮЛЭХ КОВИД-19 ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
СУДАЛГААНЫ ИНСТИТУТ

**НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН
ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ҮЗҮҮЛЭХ
КОВИД-19 ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨЛЛИЙН
ШИНЖИЛГЭЭ**

Судалгааг гүйцэтгэсэн: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт,
Нийгмийн хамгааллын бодлогын судалгааны сектор

Судалгааг гүйцэтгэсэн багийн гишүүд:

Б.Батбаатар	ХНХСИ-ийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
М.Алтансүх	ХНХСИ-ийн дэд захирал
Б.Төмөрчулуун	НХБСС-ын эрхлэгч
Т.Мөнхбат	НХБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан
Б.Эрдэнэтуяа	НХБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан
Ц.Золзаяа	НХБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо
Чингисийн өргөн чөлөө, Хөдөлмөрийн ордон, 5 давхар

Утас: (+976) 77121286

Вэб хуудас: www.rilsp.gov.mn

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	6
ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ	7
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	8
ТОВЧИЛСОН ҮГС	9
ОЙЛГОЛТ ТОДОРХОЙЛОЛТ	10
ХУРААНГУЙ	12
I БҮЛЭГ. АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	15
1.1 Танилцуулга	15
1.2 Арга зүй	17
1.3 Хамрах хүрээ	17
II БҮЛЭГ. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ ТӨЛӨВ БАЙДАЛ	20
2.1.Нийгмийн халамжийн тэтгэвэр	22
2.2.Нийгмийн халамжийн асаргааны тэтгэмжүүд.....	23
2.3.Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж.....	24
2.4.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	26
2.5.Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ	28
2.6.Нийгмийн хөгжлийн үйлчилгээ	29
2.7.Алдар цолтой ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	30
2.8.Ахмад настны тусламж, хөнгөлөлт	31
2.9.Ахмад настанд үзүүлэх хүндэтгэл, насны хишиг	33
2.10.Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлт	34
2.11.Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх эцэгт олгох тэтгэмж (мөнгөн тэтгэмж)..	36
2.12.Хүүхдийн мөнгөн тэтгэмж.....	36
2.13.Цаатан иргэний тэтгэмж.....	37
III БҮЛЭГ. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ХӨТӨЛБӨРҮҮДЭД ҮЗҮҮЛЭХ “КОВИД-19 ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨ”	39
3.1 Нийгмийн халамжийн нийт хөтөлбөрүүдэд гарсан өөрчлөлт	40
3.2 Нийгмийн халамжийн тэтгэвэрт гарсан өөрчлөлт.....	41
3.3 Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд гарсан өөрчлөлт	43
3.4. Хүүхдийн мөнгөн тэтгэмж үйлчилгээнд гарсан өөрчлөлт.....	44
3.5 Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн мөнгөн тэтгэмжийн үйлчилгээ	46
3.6 Өрхийн орлогыг хамгаалсан байдал.....	47
3.7 Ядууралд үзүүлсэн нөлөө	49
IV БҮЛЭГ. ДЭЛХИЙН БУСАД УЛС ОРНУУДЫН ТУРШЛАГА.....	53

4.1. Нийгмийн тусламж, нийгмийн даатгалын зохицуулалт, арга хэмжээ	54
4.2 Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр зохицуулалтын арга хэмжээ	57
ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	61

ӨМНӨХ ҮГ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт нь нийгмийн халамжийн үйлчилгээний хэрэгжилт, түүний үр нөлөөг судлах, үйлчилгээг сайжруулах санал, зөвлөмж боловсруулах зорилго бүхий судалгаа болон шинжилгээний ажлуудыг тогтмол хийдэг.

Нийгмийн хамгааллын чиглэлийн үйл ажиллагааны талаарх олон нийтийн ойлголт үнэлгээг сайжруулах, нийгмийн халамжийн салбар дах бодлого боловсруулагч нарыг үнэн зөв мэдээллээр хангах тал дээр онцгой анхаарч ажиллаж байна.


2020 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн “Коронавируст халдварын цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих нийгмийн хамгааллын зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 167-р тогтоолд үндэслэн “Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд үзүүлэх Ковид-19 цар тахлын нөлөөллийн шинжилгээг” батлагдсан удирдамжийн дагуу гүйцэтгэн, үр дүнгийн тайланг танилцуулж байна.

Шинжилгээний ажилд нийгмийн халамжийн 73 нэр төрлийн хөтөлбөрүүдийн 2015-2019 оны хамрагдалт болон зарцуулалтын хэмжээ, мөн Ковид-19 цар тахлын үед нийгмийн хамгааллын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдээс шалтгаалсан нөлөөллийн шинжилгээг захиргааны тоон мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийсэн.

Энэхүү шинжилгээний ажлын үр дүн нь бодлого боловсруулагч нар болон бусад хэрэглэгчдэд холбогдох бодлого, хөтөлбөр боловсруулахад ашиглагдах суурь мэдээлэл болно гэж найдаж байна.

Та бүхэн шинжилгээний ажлын үр дүнтэй танилцан, өөрсдийн үйл ажиллагаандаа ашиглахын зэрэгцээ судалгааны арга, аргачлалтай холбоотой санал хүсэлтээ бидэнд илгээж, хамтран ажиллахыг хүсье.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.БАТБААТАР

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Захиргааны тоон мэдээллийн төрөл.....	18
Хүснэгт 2. Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлагад нийгмийн халамжийн сангийн зарцуулалтын эзлэх хувь /2012-2019/	20
Хүснэгт 3. Монгол Улсын ДНБ-д нийгмийн халамжийн сангийн зарцуулалтын эзлэх хувь /2012-2019/.....	21
Хүснэгт 4. Нийгмийн халамжийн асаргааны тэтгэмжинд хамрагдсан иргэдийн тоо, /2015-2019/	23
Хүснэгт 5. Нийгмийн халамжийн асаргааны тэтгэмжид хамрагдсан иргэдэд зарцуулсан хөрөнгө 2015-2019 /тэтгэмжийн төрлөөр/ тэрбум.төг.....	24
Хүснэгт 6. Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо, /2015-2019/.....	25
Хүснэгт 7. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо /2015-2019/	27
Хүснэгт 8. Алдар цолтой ахмад настан үзүүлсэн нэмэгдэл хөнгөлөлтөд хамрагдсан иргэдийн тоо, /2015-2019/	31
Хүснэгт 9. Ахмад настанд үзүүлэх дэмжлэг хөнгөлөлтийн үйлчилгээнүүдэд хамрагдсан иргэдийн тоо, /2015-2019/	32
Хүснэгт 10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлт үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо, тэдгээрт зарцуулсан хөрөнгө, /2015-2019/ үйлчилгээний төрлөөр,	35
Хүснэгт 11. Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх эцэгт олгох тэтгэмж үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо, тэдгээрт зарцуулсан хөрөнгө, /2015-2019/ үйлчилгээний төрлөөр,	36
Хүснэгт 12. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид, тэдгээрт олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн хэмжээ төрлөөр, /2020/	41
Хүснэгт 13. Нийгмийн халамжийн тэтгэврийн үйлчилгээнүүдэд хамрагдсан иргэдийн өөрчлөлт /2019-2021/	41
Хүснэгт 14. Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогод тэтгэвэр, тэтгэмжийн орлогын эзлэх хувийн өөрчлөлт, тэтгэвэр тэтгэмжийн төрлөөр /2019-2020/	47
Хүснэгт 15. Нийгмийн тусламжийн арга хэмжээ, тоогоор	56
Хүснэгт 16. Нийгмийн даатгалын арга хэмжээ, тоогоор.....	56
Хүснэгт 17. Хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтын арга хэмжээ, тоогоор	57
Хүснэгт 18. Улс орнуудын хөтөлбөрүүдийн хуваарилалт, орлогын бүлгээр	58

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Монгол улсын нэгдсэн төсвийн зарлагад нийгмийн халамжийн сангийн зарцуулалтын эзлэх хувийн өөрчлөлт, /2012-2019 он/	21
Зураг 2. Нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдсан иргэдийн тоо, /2015-2019/	22
Зураг 3.. Нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдсан иргэдийн зарцуулсан хөрөнгө 2015-2019 /тэтгэврийн төрлөөр/	23
Зураг 4. Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдэд зарцуулсан хөрөнгө 2015-2019 /тэтгэмжийн төрлөөр/	26
Зураг 5. Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо /2019/	29
Зураг 6. Хүнс тэжээлийн дэмжлэг үйлчилгээнд хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө 2015-2019 тэрбум.төг	30
Зураг 7. Алдар цолтой ахмад настан үзүүлсэн нэмэгдэл хөнгөлөлтөд хамрагдсан иргэдэд зарцуулсан хөрөнгө, /2015-2019/ үйлчилгээний төрлөөр,.....	31
Зураг 8. Ахмад настанд үзүүлэх дэмжлэг хөнгөлөлтийн үйлчилгээнүүдэд хамрагдсан иргэдэд зарцуулсан хөрөнгө, /2015-2019/ үйлчилгээний төрлөөр,.....	33
Зураг 9. Ахмад настанд үзүүлэх хүндэтгэл, насны хишиг үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо, /2017-2019/	33
Зураг 10. Ахмад настанд үзүүлэх хүндэтгэл, насны хишиг үйлчилгээнд хамрагдсан иргэдэд зарцуулсан хөрөнгө, /2017-2019/, сая төг	34
Зураг 11. Хүүхдийн мөнгөн тэтгэмж үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн тоо, тэдгээрт зарцуулсан хөрөнгө /2015-2019/ сая.төг	37
Зураг 12. Цаатан иргэний тэтгэмжид хамрагдсан иргэдийн тоо, тэдгээрт зарцуулсан хөрөнгө, /2015-2019/ сая.төг	37
Зураг 13. Нийгмийн халамжийн сангийн зарцуулалтын өөрчлөлт /2012-2020/, тэрбум.төг	39
Зураг 14. Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлагад нийгмийн халамжийн сангийн зарцуулалтын эзлэх хувийн өөрчлөлт /2012-2020/	40
Зураг 15. Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүнд нийгмийн халамжийн сангийн зарцуулалтын эзлэх хувийн өөрчлөлт /2012-2020/	40
Зураг 16. Нийгмийн халамжийн тэтгэврийн үйлчилгээнүүдэд зарцуулсан хөрөнгийн өөрчлөлт /2019-2020/ сая.төг	42
Зураг 17. Хүнс тэжээлийн дэмжлэг үйлчилгээнд хамрагдсан иргэдийн өөрчлөлт /2019-2021/	43
Зураг 18. Хүнс тэжээлийн дэмжлэг үйлчилгээнд хамрагдсан иргэдэд зарцуулсан хөрөнгийн өөрчлөлт, /2019-2021/ тэрбум.төг.....	44
Зураг 19. Хүүхдийн мөнгөн тэтгэмж үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн өөрчлөлт /2019-2021/	45
Зураг 20. Хүүхдийн мөнгөн тэтгэмж үйлчилгээнд хамрагдсан хүүхдүүдэд зарцуулсан хөрөнгийн өөрчлөлт, тэрбум.төг /2019-2021/	45
Зураг 21. Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдэд олгож буй мөнгөн тэтгэмжид хамрагдаж буй хүүхдийн тоо болон зарцуулсан хөрөнгийн өөрчлөлт /2019-2021/ тэрбум.төг	46
Зураг 22. Өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтэц, дүнд эзлэх хувиар, /2019-2020/...	48
Зураг 23. Өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтэц, дүнд эзлэх хувиар, өрхийн тооны тэнцүү 5 бүлгээр.....	49
Зураг 24. Монгол улсын хүн амын ядуурлын түвшин,/2016-2020/	49
Зураг 25. Ядуу хүн амын тархалт суурьшлаар, /2016-2020/.....	50
Зураг 26. Ядуурлын түвшин /ҮСХ-ны хэвлэлийн бага хурлын мэдээгээр/.....	50
Зураг 27. Ядуу хүн амын эзлэх хувь, өөр өөр хувилбаруудаар /2020 оны 4-9 сар/.....	51
Зураг 28. Нийгмийн хамгааллын хариу арга хэмжээ, орлогын ангиллаар	53
Зураг 29. Нийгмийн хамгааллын хариу арга хэмжээ, бүс нутгаар	54
Зураг 30. Дэлхийн нийгмийн хамгааллын хариу арга хэмжээ, төрлөөр.....	55

ТОВЧИЛСОН ҮГС

ААН	Аж, ахуй нэгж
НХҮНМС	Нийгмийн халамж, үйлчилгээний нэгдсэн мэдээллийн систем
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХНХСИ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар
ХХҮХ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс
ХХҮГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХБХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ХМТ	Хүүхдийн мөнгөн тэтгэмж
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар

ОЙЛГОЛТ ТОДОРХОЙЛОЛТ

Нийгмийн хамгаалал	
Нийгмийн хамгааллын тогтолцоо	<p>Нийгмийн хамгааллын одоогийн тогтолцоо нь нийгмийн халамжийн (зорилтот бүлэгт чиглэсэн болон бүх нийтийг хамарсан) хөтөлбөрүүд, нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ гэсэн гурван гол үндсэн хэсгээс бүрэлдэж байна.</p> <p style="text-align: right;"><i>Эх сурвалж: Нийгмийн хамгааллын нэр томъёоны монгол-англи тайлбар толь</i></p>
Нийгмийн халамж	<p>Нийгмийн халамж гэж эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг</p> <p style="text-align: right;"><i>Эх сурвалж: Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.1</i></p>
Нийгмийн халамжийн сан	<p>Нийгмийн халамжийн сан нь мөнгөн хөрөнгийн сан байна. Халамжийн сан дараах төрөлтэй байна.</p> <ul style="list-style-type: none"> • Тэтгэвэр, тэтгэмжийн сан; • Нийгмийн үйлчилгээний сан. <p style="text-align: right;"><i>Эх сурвалж: Нийгмийн халамжийн тухай хуулийн 6.1-6.2</i></p>
Нийгмийн халамжийн тэтгэвэр	<p>Нийгмийн халамжийн тэтгэвэр гэж нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасны дагуу бүрэн болон хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэвэр авах эрх үүсээгүй иргэнд сар бүр олгох мөнгөн тэтгэвэр.</p> <p style="text-align: right;"><i>Эх сурвалж: Нийгмийн халамжийн тухай хуулийн 12.1.</i></p>
Нийгмийн халамжийн тэтгэмж	<p>Нийгмийн халамжийн тэтгэмж нь дараах төрлүүдтэй.</p> <ol style="list-style-type: none"> 1. Асаргааны тэтгэмж 2. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэний тэтгэмж 3. Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 4. Хүүхдийн мөнгөн тэтгэмж <p style="text-align: right;"><i>Эх сурвалж: Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.1</i></p>
Нийгмийн даатгалын шимтгэл	<p>Нийгмийн даатгалд даатгуулах зорилгоор даатгуулагч болон ажил олгогчоос хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын санд төлөх урьдчилсан төлбөрийг хэлнэ.</p> <p style="text-align: right;"><i>Эх сурвалж: Ndaatgal.mn</i></p>
Хувь хүний орлогын албан татвар	<p>Хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ) нь хувь хүний хөдөлмөр эрхлэх, хөрөнгө борлуулах зэргээр олсон бүх орлогод ногдох албан татвар юм.</p> <p style="text-align: right;"><i>Эх сурвалж: Mongolbank.mn</i></p>
Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	<p>Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ) нь бизнесийн үйл ажиллагаанаас орсон орлогод ногдох албан татвар юм.</p> <p style="text-align: right;"><i>Эх сурвалж: Mongolbank.mn</i></p>

Эдийн засаг	
Улсын төсөв	Улсын Их Хурлаас баталсан, Засгийн газар болон улсын төсөвт харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсвийг; <i>Эх сурвалж: Төсвийн тухай хуулийн 4.1.6</i>
Орон нутгийн төсөв	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан, тухайн шатны төсөвт харьяалагдах ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсвийг; <i>Эх сурвалж: Төсвийн тухай хуулийн 4.1.27</i>
Дотоодын нийт бүтээгдэхүүн	Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) нь тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн нэг жилийн хугацаанд шинээр бий болгосон нийт нэмэгдэл өртгийн хэмжээ юм. ДНБ-ийг үйлдвэрлэлийн, эцсийн ашиглалтын, орлогын гэсэн 3 аргаар тооцно. <i>Эх сурвалж: 1212.mn</i>
Өрхийн орлого	Өрхийн гишүүдийн хийж гүйцэтгэсэн ажлынхаа төлөө авсан, эсвэл бүтээгдэхүүн үйлчилгээг худалдан авагчдад зарж борлуулснаас олсон мөнгө <i>Эх сурвалж: Mongolbank.mn</i>
Ядуурал	Ядуурлын статистикт туйлын (абсолют), харьцангуй гэсэн үндсэн хоёр ойлголт давамгайлдаг. Туйлын (абсолют) ядуу гэж амьжиргааны наад захын зайлшгүй хэрэглээнээс доогуур хэрэглээтэй хүн амыг хэлнэ. Харьцангуй ядуу гэж тухайн хүн өөрийн хэрэгцээгээ хэрхэн үнэлж, бусадтай харьцуулж байгаагаар буюу хэрэгцээгээ өөрийн нөөц боломжтойгоо уялдуулан харьцуулж гаргасан дүгнэлтээр ядуу гэж тодорхойлж байгааг хэлнэ. Туйлын ядууралд амьжиргааны наад захын зайлшгүй хэрэгцээг голлон судалдаг бол харьцангуй ядуурал нь орлого, баялгийн хуваарилалт болон ядуучуудыг нийгмийн бусад бүлэг, давхаргатай харьцуулан судална. <i>Эх сурвалж: Ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал</i>
Ядуурлын шугам	Хэрэглээг тооцсоны дараа хүн амыг ядуу ба ядуу бус гэж ангилж, сонгогдсон үзүүлэлтүүдтэй харьцуулах боломжтой хэмжигдэхүүн хэрэгтэй. Энэхүү хэмжигдэхүүнийг ядуурлын шугам гэж ойлгож болно.
Монгол улсын нэгдсэн төсвийн зарлага	Төсвийн зарлага гэж төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсан төсвөөс хуваарилан, зарцуулах хөрөнгийг хэлнэ. <i>Эх сурвалж: 1212.mn</i>

ХУРААНГУЙ

Шинжилгээний ажил нь 2020 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн “Коронавируст халдварын цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих нийгмийн хамгааллын зарим арга хэмжээний тухай” 167-р тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдон нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн хэрэгжилт, хамрагдалт, халамжийн сангийн зарцуулалтад Ковид-19 цар тахал хэрхэн нөлөөлж байгааг судлах зорилготой.

Шинжилгээний ажилд нийгмийн халамж хүртэгсэд болон, зарцуулагдаж буй мөнгөн дүнтэй холбоотой албан ёсны захиргааны статистик мэдээллийг холбогдох байгууллагуудаас цуглуулж нэгтгэсэн. Холбогдох тоон мэдээлэл дээр үндэслэн харьцуулалтын аргыг ашиглан мэдээллийг шинжилж, тайланг боловсруулсан.

Товч үр дүн:

2012-2016 онуудад Нийгмийн халамжийн сангийн зарцуулалтын хэмжээ Монгол Улсын ДНБ-ний 1.1-1.2 хувийг эзэлж байсан бол 2017 оноос ДНБ-д эзлэх хэмжээ 0.78 пунктээр өссөн буюу, ДНБ-ний 1.9 хувийг эзэлж байна. Энэ нь “Хүүхдийн мөнгөн тэтгэмж”-ийг нийгмийн халамжийн сангаас олгодог болсонтой холбоотой. 2019 онд нийгмийн халамжийн сангийн зарцуулалт Монгол Улсын ДНБ-ний 1.8 хувийг эзэлж байна.

Нийгмийн халамжийн сангийн нийт зарцуулалтын хэмжээ 2020 оны жилийн эцсийн байдлаар 1 586.9 тэрбум төгрөг байсан нь өмнөх оны мөн үеэс 2.35 дахин өссөн буюу цэвэр өсөлтийн хувь 135.6 хувь байна. 2017 онд нийгмийн халамжийн сангийн зардал 526.5 тэрбум төгрөгт хүрч байсантай харьцуулахад мөн л 3 дахин өсжээ.

Нийгмийн халамжийн сангаас 2020 онд 2.6 (давхардсан тоогоор) сая хүнд 1.6 их наяд төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлт олгосон нь өмнөх оноос нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид 194.6 (8.2%) мянгаар, үйлчилгээнд олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн хэмжээ 912.5 (2.4 дахин) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

“Ковид-19” цар тахлаас шалтгаалан олгож буй мөнгөн дүнд өөрчлөлт орсон үйлчилгээнүүдийн хувьд хүүхдийн мөнгөн тэтгэмж нийт өөрчлөлтийн голлох хувийг эзэлж байна. Харин мөнгөн дүнд өөрчлөлт ороогүй үйлчилгээнүүд дотроос олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо 28.7 хувиар, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт 14.5 хувиар буурсан байгаа бол алдар цолтой ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт үйлчилгээнд хамрагдсан ахмад настны тоо 24.6 хувиар өссөн байна. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо жилийн эцсийн байдлаар буурсан байгаа нь олон нийтийн хөл хорио тогтоосноос шалтгаалж сургалт зохион байгуулах, сэргээн засах үйлчилгээнд хамруулах, зөвлөгөө өгөх зэрэг үйлчилгээнүүдийг явуулах боломжгүй болсонтой холбоотой гэж хэлж болохуйц юм. Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж үйлчилгээнд зарцуулж буй мөнгөн дүн 35.2 хувиар, цаатан иргэний тэтгэмж 13.7 хувиар өссөн бол ахмад настны дэмжлэг хөнгөлөлт үйлчилгээнд зарцуулж буй мөнгөн дүн 5.9 хувиар буурсан байна.

Хүүхдийн мөнгөн тэтгэмж үйлчилгээнд 2020 оны жилийн эцсийн байдлаар 1 053.0 тэрбум төгрөгийг зарцуулсан нь мөн оны өмнөх үеэс 823.4 тэрбум төгрөгөөр (4.6) дахин нэмэгдэж, нийгмийн халамжийн сангийн зарцуулалтыг ихээр өсгөсөн. “Ковид-19” цар тахлын үед нэмэгдсэн нийт 912.5 тэрбум төгрөгийн 90 хувийг хүүхдийн мөнгөн тэтгэмж үйлчилгээний нэмэгдэл эзэлж байна.

2020 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн халамжийн тэтгэвэрт 162 897 сая төгрөг зарцуулсан нь өмнөх оны мөн үеэс 1.5 дахин нэмэгдсэн байна. Нийт нэмэгдсэн мөнгөн дүн

нь 912.5 тэрбум төгрөгийн 5.6 хувийг эзэлж байгаа буюу 51.3 тэрбум төгрөгийг “Ковид-19” цар тахлын дараа нэмж санхүүжүүлсэн байна.

Хамгийн бага орлоготой бүлгийн өрхүүдийн сарын дундаж мөнгөн орлогын тал хувийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого бүрдүүлж байхад хамгийн их орлоготой бүлгийн өрхүүдийн хувьд тэдний сарын дундаж мөнгөн орлогын дөнгөж аравны нэгийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого эзэлж байна. Эндээс харахад бага орлоготой өрхүүдийн амьжиргаанд тэтгэвэр, тэтгэмжийн орлогын үзүүлэх нөлөө их байдаг нь харагдаж байна.

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 2020 оны жилийн эцсийн байдлаар 55.4 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 19.6 тэрбум (54.7) хувиар нэмэгдсэн байна. “Ковид-19” цар тахлын үед нэмэгдсэн нийт 912.5 тэрбум төгрөгийн 2.1 хувийг хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний нэмэгдэл эзэлж байна. Хүнс тэжээлийн дэмжлэг үйлчилгээ нь өрхийн гишүүдийн хүнсний наад захын хэрэгцээг хангах зорилго бүхий бодлого ч харьцангуй бага төсөвтэй, хязгаарлагдмал цар хүрээг хамарсан байна. Хагас жилийн байдлаар харьцуулан харвал 7.3 тэрбум (46.2) хувиар нэмэгдсэн бол 2021 оны хагас жилтэй харьцуулахад 6.5 тэрбум (28.1) хувиар буурсан байна.

2020 оны хагас жилээр байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдэд олгох мөнгөн тэтгэмжийн үйлчилгээнд 10 066 хүүхэд хамрагдаж 12.3 тэрбум төгрөг зарцуулсан нь өмнөх оны мөн үеэс 159 хүүхэд (1.6) хувиар нэмэгдэж зарцуулалтын хэмжээ 3.1 тэрбум (33.6) хувиар нэмэгдсэн байна. Харин 2021 оны хагас жилийн байдлаар 11 494 хүүхэд хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 1 428 хүүхэд (14.1) хувиар нэмэгдэж зарцуулалтын хэмжээ 4.6 тэрбум (37.3) хувиар нэмэгдсэн байна. “Ковид-19” цар тахлын үед нэмэгдсэн нийт 912.5 тэрбум төгрөгийн 1.1 хувь (10.5) тэрбум төгрөгийг байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн мөнгөн тэтгэмж үйлчилгээний нэмэгдэл эзэлж байна.

Тэтгэвэр, тэтгэмжийн орлогыг төрлөөр нь задалж харвал, 2020 онд өмнөх оноос улсын дунджаар нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогод өндөр насны тэтгэврийн эзлэх хувь 0.6 пунктээр, хүүхдийн мөнгөний эзлэх хувь 2.1 пунктээр, жирэмсэн болон амаржсан, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжийн эзлэх хувь 0.4 пунктээр нэмэгдсэн байна.

Хэрвээ “Ковид-19” цар тахал дэгдээгүй байсан бол ядуурлын түвшин 24.3 хувь болж 4.1 пунктээр буурсан байхаар тооцоологдсон байна. Байршлаар харвал хот суурин газарт 3.7 пунктээр буурах боломжтой байсан бол хөдөө орон нутагт 4.9 пунктээр буурах боломжтой байсан байна. Ядуурлын түвшин 2020 онд 2018 оноос бага зэрэг буурсан үр дүнтэй байна. “Ковид-19” цар тахлын өрхийн амьжиргаанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор засгийн газрын авч хэрэгжүүлсэн нийгмийн халамж, нийгмийн хамгааллын олон талт арга хэмжээ нь ядуурлын тэлэлтийг хязгаарлахад чухал үүрэг гүйцэтгэсэн нь тодорхой харагдаж байна.

2020 оны 3 дугаар сараас 2021 оны хагас жилийн байдлаар Дэлхийн 222 улс орон, нутаг дэвсгэрт нийт 3 333 нийгмийн хамгааллын бодлогын арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Цар тахлын сөрөг нөлөөг бууруулах, нийгэм-эдийн засаг, хөдөлмөрийн зах зээлийг тогтвортой байлгахад нийгмийн хамгааллын хариу арга хэмжээнүүд голлох үүрэг гүйцэтгэсэн. Цар тахлын эхэн үеэс Засгийн газрууд нийгмийн тусламж, хөдөлмөрийн зах зээл, нийгмийн даатгалын бодлогын холимог арга хэмжээнүүдийг нэвтрүүлсэн.

Бүлэг I

АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

I БҮЛЭГ. АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1 Танилцуулга

2020 оны 1 дүгээр сараас эхлэн БНХАУ-ын Ухань хотоос Ковид-19 вирусн анхны тохиолдол бүртгэгдсэнээс хойш дэлхий дахинд улс орны нийгэм, эдийн засагт хүчтэйгээр нөлөөлж байгаа билээ. Ковид-19 цар тахал нь эрүүл мэндийн болон хорио цээрээс үүдэлтэй эдийн засгийн сөрөг үр дагавар үүсгээд байна.

Цар тахал дэгдсэнээр зүүн азийн бүс нутгийн засгийн газрууд ДНБ-нийхээ дунджаар 5 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг нийтийн эрүүл мэндийг хамгаалах тогтолцоог бэхжүүлэх, айл өрхүүдийг дэмжих, аж ахуйн нэгжүүдийг хаалгаа барихаас сэргийлэхэд зориулсан байна.¹

Хонконг, Хятадад насанд хүрсэн иргэддээ 1 280 долларын нэг удаагийн бэлэн мөнгөний тусламж үзүүлэхээр болсон ба энэ нь эдийн засгийг 1 хувиар нэмэгдүүлнэ гэж үзэж, нийгмийн халамжийн тэтгэмжээ олгосон байна.²

Цар тахлаас шалтгаалсан эдийн засгийн хүндрэл Монгол улсад ч мөн адил хүндрэл учруулсаар байна. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хөл хорио хоёр жил гаруй хугацааны турш үргэлжилж байгаа нь иргэдийн амьдрал, жижиг аж ахуй нэгж байгууллагад маш хүндээр тусч байна.

Тиймээс Монгол улсын Засгийн газар дараах хэд хэдэн шийдвэрийг гаргасан. 2020 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн “Коронавируст халдварын цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих нийгмийн хамгааллын зарим арга хэмжээний тухай” 167-р тогтоол гарсан.

Энэхүү тогтоолын дагуу нийгмийн хамгааллын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг дурдвал:

- 18 хүртэлх насны хүүхэд бүрт олгож байгаа хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлж 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд сар бүр 100 000 (нэг зуун мянган) төгрөг олгох³. *Нийт 1 сая 250 мянган хүүхэд хүүхдийн мөнгө авах бөгөөд 300 тэрбум төгрөг зарцуулсан.*
- Нийгмийн халамжийн сангаас олгодог халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлж 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд сар бүр 288 000 (хоёр зуун наян найман мянган) төгрөг олгох. *Тэтгэвэр, тэтгэмжид хамрагдагчид 180 мянга орчим хүн байна.*
- Хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд олгож байгаа хүнсний бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичгийн үнийн дүнг нэмэгдүүлж 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс сар бүр нэг хүүхдэд 16 000 (арван зургаан мянган) төгрөг, насанд хүрсэн нэг гишүүнд 32 000 (гучин хоёр мянган) төгрөг 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд олгох⁴. *Ингэснээр 122 мянган насанд хүрэгч, 118 мянган хүүхэд хүнсний эрхийн бичгийн дэмжлэг авна.*

Эдгээр хүүхдийн мөнгөн тэтгэмж, тэтгэвэр, тэтгэмжийг олон нийтийн бөөгнөрөл үүсгэхгүйгээр, халдвар, хамгааллын дэглэм, горимыг чанд сахиулсны үндсэн дээр ямар

¹ <https://www.worldbank.org/mn/news/press-release/2020/09/28/east-asia-and-pacific-pandemic-triple-shock-hitting-economies-across-region>

² https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/documents/briefingnote/wcms_739587.pdf

³ МУ-ын Засгийн газрын 248-р тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон.

⁴ МУ-ын Засгийн газрын 126-р тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон.

нэгэн хүндрэлгүй, түргэн шуурхай зохион байгуулж олгохыг 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн Засгийн газрын 183-р тогтоолоор Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдад даалгасан. Нийгмийн халамжийн сангаас нийт 73 төрлийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээг санхүүжүүлдэг. Тэгвэл коронавируст цар тахлын үед нийгмийн халамжийн сангийн зарцуулалтад ямар өөрчлөлт орсон, ямар хөтөлбөрүүдийн хүрээнд зарцуулалт, хамрагдалтын түвшин өссөн болон буурсан үзүүлэлттэй байгаа, үүнд ямар хүчин зүйлүүд нөлөөлсөн талаарх шинжилгээг хийх хэрэгцээ гарч байна.

Зорилго

Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн хэрэгжилт, хамрагдалт, халамжийн сангийн зарцуулалтад “Ковид-19” цар тахал хэрхэн нөлөөлж байгааг судлах үндсэн зорилготой. Зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж байна.

1. Нийгмийн халамжийн сангийн өөрчлөлтийг судлах, зарцуулсан мөнгөн дүнгийн өөрчлөлтийг тодорхойлох;
2. Цар тахлын үеийн нийгмийн халамжийн үйлчилгээнүүдийн хэрэгжилт, үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоонд харьцуулсан шинжилгээ хийх;
3. Нийгмийн халамжийн сангийн зардлын улсын төсвийн зардалд эзлэх хувь хэмжээний өөрчлөлт, ДНБ-нд эзлэх хувийн өөрчлөлт зэргийг тогтоох;
4. Өрхийн орлогод нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж зэрэг нь хэрхэн нөлөө үзүүлснийг тодорхойлох;
5. Бусад улс орнуудын “Ковид-19” цар тахлын улмаас авч хэрэгжүүлсэн нийгмийн хамгааллын арга хэмжээнүүдийг судлах.

1.2 Арга зүй

Шинжилгээний ажилд хоёрдогч эх сурвалжийн тоон мэдээлэлд харьцуулалтын аргыг ашиглан, дүн шинжилгээ хийлээ. Шинжилгээний ажилд нийгмийн халамж хүртэгсэд болон, зарцуулагдаж буй мөнгөн дүнтэй холбоотой албан ёсны захиргааны статистик мэдээллийг холбогдох байгууллагуудаас цуглуулж, нэгтгэсэн.

1.3 Хамрах хүрээ

Нөлөөллийн шинжилгээний ажилд нийгмийн халамж хүртэгсэдтэй холбоотой дараах захиргааны хоёрдогч тоон мэдээнд дүн шинжилгээ хийлээ. Үүнд:



Өрхийн орлого

- Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа 2020
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо



Улсын төсвийн зардал, ДНБ

- Үндэсний тооцооны үзүүлэлт болох ДНБ болон улсын нэгдсэн төсвийн зарцуулалтын хэмжээг ҮСХ-оос анхдагч мэдээлэл болгон цуглуулсан.
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо



Нийгмийн халамж хүртэгсдийн тоон мэдээлэл

- Нийгмийн халамж, үйлчилгээний нэгдсэн мэдээллийн систем (WAIS) болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын статистик эмхэтгэл 2019-өөс мэдээлэл цуглуулна.
Эх сурвалж: ХХҮЕГ



Нийгмийн халамж хүртэгсдийн тоон мэдээлэл

- Нийгмийн халамж, үйлчилгээний нэгдсэн мэдээллийн систем (WAIS) болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын статистик эмхэтгэл 2020-оос мэдээлэл цуглуулна.
Эх сурвалж: ХХҮЕГ

Хүснэгт 1. Захиргааны тоон мэдээллийн төрөл

№	Тоон мэдээллийн төрөл	Үзүүлэлт	Эх сурвалж
1	Монгол улсад “Хүүхдийн мөнгөн тэтгэмж” авч буй тоон мэдээ	- Хамрагдаж буй хүүхдийн тоо - Зарцуулалтын дүн - Холбогдох улирал, жил	ХХҮЕГ “Нийгмийн халамжийн захиргааны мэдээллийн сан”
2	“Нийгмийн халамжийн тэтгэвэр” авч буй ахмад настны тоон мэдээ	- Хамрагдаж буй иргэдийн тоо - Зарцуулалтын дүн - Холбогдох улирал, жил	ХХҮЕГ “Нийгмийн халамжийн захиргааны мэдээллийн сан”
3	Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн мөнгөн тэтгэмж авч буй хүүхдийн тоон мэдээ	- Хамрагдаж буй иргэдийн тоо - Зарцуулалтын дүн - Холбогдох улирал, жил	ХХҮЕГ “Нийгмийн халамжийн захиргааны мэдээллийн сан”
4	“Хүнс тэжээлийн дэмжлэг” авч буй иргэдийн тоон мэдээ	- Хамрагдаж буй иргэдийн тоо - Зарцуулалтын дүн - Холбогдох улирал, жил	ХХҮЕГ “Нийгмийн халамжийн захиргааны мэдээллийн сан”
5	Нийгмийн халамжийн 73 төрлийн үйлчилгээний тоон мэдээ	- Хамрагдаж буй иргэдийн тоо - Зарцуулалтын дүн - Холбогдох улирал, жил	ХХҮЕГ “Нийгмийн халамжийн захиргааны мэдээллийн сан”
6	Улсын төсвийн зардал	- Холбогдох он - Холбогдох улирал	ҮСХ
7	МУ-ын ДНБ	- Холбогдох он - Холбогдох улирал	ҮСХ
8	Өрхийн орлого	- ӨНЭЗС /2020/	ҮСХ

Бүлэг II

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН
ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ,
ТӨЛӨВ БАЙДАЛ 2015-2019

II БҮЛЭГ. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ ТӨЛӨВ БАЙДАЛ

Нийгмийн халамжийн 73 төрлийн тусламж, хөнгөлөлт үйлчилгээг нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлэн зарцуулж байна⁵. Нийгмийн халамжийн сангийн зарцуулалт жил бүр өсөх хандлагатай байгаа ба улсын төсөвт эзлэх хувь 2017 онд 2 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Улсын төсвийн зарцуулалт 2012-2019 онуудад жигд тасралтгүй өссөн бөгөөд нийт зарцуулалтын дийлэнх хувийг урсгал зардал эзэлж байна. Харин Нийгмийн халамжийн сангийн зарцуулалтын мэдээллийг 2012-2016 он хүртэл ҮСХ-ны Нийгмийн даатгал, халамж /2017/ тайлан мэдээллийн дүнг удиртгал болгосон бол, 2017 оны зарцуулалтын хэмжээг, ҮСХ-ны мэдээлсэн тоон мэдээн дээр хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэмжээг нэмсэн байдлаар, 2018-2019 оны зарцуулалтын хэмжээг Сангийн яамны МУ-ын 2018, 2019 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг эх сурвалж болгон ашиглан тооцсон.

Хүснэгт 2. Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлагад нийгмийн халамжийн сангийн зарцуулалтын эзлэх хувь /2012-2019/

Он	Улсын төсвийн зарцуулалт/ сая/	Нийгмийн халамжийн сангийн зарцуулалт / сая/	Улсын төсөвт эзлэх хувь
2012	6,017,800.60	181,444.80	3.0
2013	6,164,685.20	233,243.60	3.8
2014	7,144,567.98	241,792.90	3.4
2015	7,137,973.86	256,869.50	3.6
2016	9,495,332.88	266,601.50	2.8
2017	9,017,318.60	526,511.40	5.8
2018	9,222,928.50	622,700.00	6.8
2019	11,429,391.60	673.600.00	5.9


Эх сурвалж: 1212.mn /ҮСХ/

2012-2016 онуудад Нийгмийн халамжийн сангийн зарцуулалтын хэмжээ улсын нийт төсвийн зарцуулалтын 2.8-3.7 хувийг эзэлж байсан бол 2017-2019 онуудад огцом нэмэгдсэн нь хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийгмийн халамжийн сангаас олгодог болсонтой холбоотой юм. 2017 оноос Хүүхдийн мөнгийг “Нийгмийн халамжийн тухай хууль”-ийн 13 дугаар зүйлийн 13.1.5-д нийгмийн халамжийн тэтгэмжийн нэг төрөл болгон хуульчилж, хүүхдийн мөнгөн тэтгэмж хэлбэрээр олгох болсон. “Хүний хөгжил сангийн тухай хууль” 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр хүчингүй болсонтой холбогдуулан Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар “Хүүхдийн мөнгө олгох журам”-ыг баталсан байна. Хүүхдийн мөнгө олгох журамд орсон гол өөрчлөлт нь санхүүжилтийн эх үүсвэр юм. Өмнө нь хүүхдийн мөнгийг “Хүний хөгжил сан”-аас санхүүжүүлдэг байсан бол шинэ журмаар нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлэхээр зохицуулсан.

Энэхүү хуулийн зохицуулалтаас хойш Нийгмийн Халамжийн Сангийн зарцуулалт нилээдгүй өндөр хувиар өссөн. 2017 онд нийгмийн халамжийн сангийн зарцуулалт улсын төсвийн зарцуулалтын 5.8 хувийг эзэлж байсан бол, 2019 онд 5.9 буюу өмнөх онуудтай харьцуулахад 3-3.3 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

⁵ Монгол Улсын Засгийн газраас үзүүлдэг нийгмийн халамжийн үйлчилгээний жагсаалтыг Хавсралт 1-с үзнэ үү.

Зураг 1. Монгол улсын нэгдсэн төсвийн зарлагад нийгмийн халамжийн сангийн зарцуулалтын эзлэх хувийн өөрчлөлт, /2012-2019 он/



2012-2016 онуудад Нийгмийн халамжийн сангийн зарцуулалтын хэмжээ Монгол Улсын ДНБ-ний 1.1-1.2 хувийг эзэлж байсан бол 2017 оноос ДНБ-д эзлэх хэмжээ 0.78 пунктээр өссөн буюу, ДНБ-ний 1.9 хувийг эзэлж байна. Энэ нь дээр дурдсанчлан “Хүүхдийн мөнгөн тэтгэмж”-ийг нийгмийн халамжийн сангаас олгодог болсонтой холбоотой. 2019 онд нийгмийн халамжийн сангийн зарцуулалт Монгол Улсын ДНБ-ний 1.8 хувийг эзэлж байна.

Хүснэгт 3. Монгол Улсын ДНБ-д нийгмийн халамжийн сангийн зарцуулалтын эзлэх хувь /2012-2019/

Он	МУ-ын ДНБ /сая төгрөг/	Нийгмийн халамжийн сангийн зарцуулалт /сая төгрөг/	ДНБ-д эзлэх хувь
2012	16,688,419.6	181,444.8	1.1
2013	19,174,242.6	233,243.6	1.2
2014	22,227,054.3	241,792.9	1.1
2015	23,150,385.6	256,869.5	1.1
2016	23,942,866.4	266,601.5	1.1
2017	27,876,297.2	526,511.4	1.9
2018	32,411,224.1	622,700.0	1.9
2019	37,392,629.1	673,600.0	1.8

Эх сурвалж: 1212.mn /УСХ/

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ) одоогоор нийгмийн халамжийн 72 үйлчилгээ, мөн Хүүхдийн мөнгөний хөтөлбөрийг (ХМХ) хэрэгжүүлж байна. Нийгмийн халамжийн хөтөлбөрүүд нь хамрагдах нөхцөл хангасан иргэдэд хамгийн наад захын нийгмийн халамж үзүүлэх зорилготой. Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг Нийгмийн халамжийн тухай хууль (2019) болон хөтөлбөрт хамрагдах шалгуурыг тогтоосон бусад хууль тогтоомжид тодорхойлсон байдаг.

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнээс бусад бүх мөнгөн тэтгэмжийн болон нөхөн олговрын хөтөлбөрүүд нь хүн амын бүлгээр буюу категорин аргаар зорилтот бүлгээ тодорхойлсон байдаг. Ядуу иргэдэд тухайлан чиглэсэн (өөрөөр хэлбэл, ядуу иргэдийг зорилтот бүлгээ болгосон) ганц хөтөлбөр бол хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ бөгөөд үр шим хүртэх зорилтот бүлгээ ООТА ашиглан тодорхойлдог.

Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг дараах 13 бүлэгт ангилан, авч үзье.


- Нийгмийн халамжийн тэтгэвэр
- Нийгмийн халамжийн асаргааны тэтгэмж
- Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ
- Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ
- Нийгмийн хөгжлийн үйлчилгээ
- Алдар цолтой ахмад настанд олгох нэмэгдэл, хөнгөлөлт
- Ахмад настанд үзүүлэх хүндэтгэл, насны хишиг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлт
- Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх эцэгт олгох тэтгэмж (мөнгөн тэтгэмж)
- Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ
- Хүүхдийн мөнгөн тэтгэмж
- Цаатан иргэдийн тэтгэмж

2.1. Нийгмийн халамжийн тэтгэвэр

Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр авах эрх үүсэхгүй байгаа иргэдэд сар тутамд олгох мөнгөн тэтгэмж. Үүнд: ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, асран хамгаалах эцэг эхгүй 18 нас хүрээгүй хүүхэд, 18-аас доош насны дөрөв ба түүнээс олон хүүхэдтэй ганц бие, 45 нас хүрсэн эх, 50 нас хүрсэн эцэг орно. Сард олгох тэтгэврийн хэмжээ 188 мянган төгрөг.

2019 оны байдлаар ХБИ-ний тэтгэвэрт 42 468 иргэн хамрагдсан бол, тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийн тэтгэвэрт 16 442 иргэн, ахмад настны тэтгэвэрт 3 595 иргэн, 16 насанд хүрсэн одой иргэний тэтгэвэрт 116 иргэн, өрх толгойлсон эх, эцгийн тэтгэвэрт 19 иргэн хамрагдсан байна. Ахмад настны тэтгэвэр үйлчилгээний хувьд хамрагдсан иргэдийн тоо 2018-2019 оны хооронд 1 057 иргэнээр өссөн нь хамгийн өндөр үзүүлэлт байна.

Зураг 2. Нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдсан иргэдийн тоо, /2015-2019/




Эх сурвалж: ХХҮЕГ, НХҮНМС-ийн тайлан

Нийгмийн халамжийн тэтгэврийн төрлүүд дотроос хамгийн өндөр зарцуулалтын хувийг ХБИ-ний тэтгэвэр эзэлж байгаа бөгөөд энэхүү тэтгэврийн зарцуулсан хөрөнгө жилээс жилд нэмэгдэх хандлагатай байна. Харин тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийн тэтгэвэр, ахмад настны тэтгэврийн зарцуулсан хөрөнгө эсрэгээрээ буурч байна. 16 насанд хүрсэн одой иргэний тэтгэвэр, өрх толгойлсон эх эцгийн тэтгэвэрт хамрагдаж байгаа иргэд

болон зарцуулсан хөрөнгийн хэмжээ 0.01-0.3 хувийн хооронд байгаа буюу маш бага хувийг эзэлж байна.

Зураг 3. Нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдсан иргэдийн зарцуулсан хөрөнөө 2015-2019 /тэтгэврийн төрлөөр/



Эх сурвалж: ХХҮЕГ, НХҮНМС-ын тайлан

2.2. Нийгмийн халамжийн асаргааны тэтгэмжүүд

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай болон онцгой тохиолдолд амьжиргааны дэмжлэг авах шаардлагатай болсон, үүний дотор бүтэн өнчин хүүхдийг хууль ёсоор асран хамгаалж байгаа иргэн, тэжээн тэтгэх үр хүүхэдгүй ганц бие ахмад настан, мөн байнгын асаргаа шаардлагатай хүнийг асарч байгаа иргэдэд үзүүлж буй мөнгөн тэтгэмж орно.

Нийгмийн халамжийн асаргааны тэтгэмжид хамрагдаж байгаа иргэдийн тоо 2015-2016 оны хооронд 14 156 иргэнээр буюу 31.2 хувиар өссөн байна. Асаргааны тэтгэмжүүд дотроос хамгийн олон хүн хамрагдаж байгаа тэтгэмж бол эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа иргэнд олгож буй тэтгэмж байна. Энэхүү тэтгэмжид хамрагдаж буй иргэдийн тоо 2015-2019 оны хооронд тасралтгүй өсөж байгаа бөгөөд, 2019 онд 62 264 иргэд хамрагдаж, тухайн онд хамрагдсан иргэдийн 95.6 хувийг бүрдүүлж байна. Харин тэжээн тэтгэх үр хүүхэд, төрөл садангийн хүнгүй ганц бие ахмад настан болон ХБИ иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэдэд олгож буй тэтгэмжид хамрагдсан иргэдийн тоо жилээс жилд буурсаар байна.

Хүснэгт 4. Нийгмийн халамжийн асаргааны тэтгэмжинд хамрагдсан иргэдийн тоо, /2015-2019/

Асаргааны тэтгэмжүүд	2015	2016	2017	2018	2019
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа иргэн	2 345	2 462	2 367	2 278	2 308
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан хүүхдийг Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэн	82	452	229	234	302
	315	3 703	1 464	291	235

<i>Тэжээн тэтгэх үр хүүхэд, төрөл садангийн хүнгүй ганц бие ахмад настан болон ХБИ иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэн</i>					
<i>Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон, ХБХ ба иргэнийг асарч байгаа иргэн</i>	42 515	52 796	54 588	56 284	62 264
Нийт	45 257	59 413	58 648	59 087	65 109

Эх сурвалж: ХХҮЕГ, НХҮНМС-ын тайлан

Асаргааны тэтгэмжүүдийн нийт зарцуулалтын хэмжээ 2015-2019 онуудын хооронд тасралтгүй өссөн байна. 2019 оны байдлаар эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон, ХБХ ба иргэнийг асарч байгаа иргэдэд 45.14 тэрбум төгрөг зарцуулсан бол бусад үйлчилгээнүүдэд 2.5 тэрбум төгрөгийн халамж үзүүлсэн байна.

Хүснэгт 5. Нийгмийн халамжийн асаргааны тэтгэмжид хамрагдсан иргэдэд зарцуулсан хөрөнгө 2015-2019 /тэтгэмжийн төрлөөр/ тэрбум.төг

Асаргааны тэтгэмжүүд	2015	2016	2017	2018	2019
<i>Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа иргэн</i>	1.73	1.62	1.85	1.93	2.07
<i>Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан хүүхдийг Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэн</i>	0.06	0.33	0.18	0.20	0.26
<i>Тэжээн тэтгэх үр хүүхэд, төрөл садангийн хүнгүй ганц бие ахмад настан болон ХБИ иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэн</i>	0.20	1.95	0.83	0.21	0.17
<i>Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон, ХБХ ба иргэнийг асарч байгаа иргэн</i>	26.4	30.09	33.0	36.84	45.14
Нийт	28.39	33.99	35.86	39.18	47.64

Эх сурвалж: ХХҮЕГ, НХҮНМС-ын тайлан

2.3. Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж

Гэнэтийн аюул осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад шалтгаанаар гэр оронгүй, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон болон амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрх, 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн, хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай, 4 ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон эцэг эхэд олгох тэтгэмжийн хэмжээ 1.2 сая төгрөг бөгөөд нэг удаа олгоно.

Дээрх үйлчилгээнүүд дотроос байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэн болон 16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох тэтгэмж үйлчилгээнд хамрагдаж буй иргэдийн тоо хамгийн их хувийг эзэлж байгаа бөгөөд жилээс жилд тасралтгүй өссөөр байна. 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд олгох тэтгэмж болон, гэр оронгүй тэнэмэл өрх, иргэнд олгох мөнгөн тэтгэмж үйлчилгээнүүдэд хамрагдаж буй иргэдийн тоо тогтмол буурсаар байна. 2019 оны байдлаар 37 гэр оронгүй тэнэмэл иргэн энэхүү үйлчилгээнд хамрагдсан байгаа бөгөөд 2015 оны тоон мэдээлэлтэй харьцуулахад 80.0 хувиар буурсан байна. Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэнд олгож буй мөнгөн тэтгэмж үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо 2017 онд 205 байсан бол 2018 онд 72.2 хувиар өсөж, 740 иргэн хамрагдсан байна.

Хүснэгт 6. Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо, /2015-2019/

Тэтгэмжийн төрөл	2015	2016	2017	2018	2019
<i>Гэнэтийн аюул, осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад шалтгаанаар гэр оронгүй, болсон болон амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрх</i>	950	918	812	892	932
<i>18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн</i>	665	691	523	506	508
<i>Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн</i>	179	696	205	740	416
<i>Гэр оронгүй тэнэмэл өрх, иргэн</i>	301	99	74	45	37
<i>16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох тэтгэмж</i>	7 926	7 303	10 305	10 922	11 691
<i>Байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэн;</i>	29 840	49 512	39 467	39 921	40 402
Нийт	39 861	59 219	51 386	53 026	53 986

Эх сурвалж: ХХҮЕГ, НХҮНМС-ын тайлан

Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн үйлчилгээнд зарцуулсан хөрөнгийн хувьд 16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмжийн үйлчилгээ дунджаар 50.0 хувийг дангаараа бүрдүүлж байна. Үйлчилгээний хувьд нэг хүүхдэд олгох мөнгөн тэтгэмжийн хэмжээ нь жилд 2.08 сая төгрөг бөгөөд байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэнд олгох мөнгөн тэтгэмжээс 3 дахин бусад үйлчилгээнүүдийн мөнгөн дүнгээс 2 дахин өндөр байна. Гэнэтийн аюул, осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад шалтгаанаар гэр оронгүй, болсон болон амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрхөд олгох тэтгэмжийн үйлчилгээнд хамрагдаж буй иргэдийн тоо 2016-2019 оны хооронд бага зэрэг өссөөр байгаа боловч нийт зарцуулалтад эзлэх хувийн жин буурч байна. 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд олгох тэтгэмжийн үйлчилгээнд хамрагдаж буй иргэдийн тоо мөн буурсаар байгаа бөгөөд, нийт зарцуулалтад эзлэх хувийн жин ч тасралтгүй буурсаар байна.

Зураг 4. Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдэд зарцуулсан хөрөнгө 2015-2019 /тэтгэмжийн төрлөөр/



Эх сурвалж: ХХҮЕГ, НХҮНМС-ын тайлан

2.4. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээнд зөвлөгөө өгөх, сэргээн засах, түр байрлуулан асрамжлах, өдрийн үйлчилгээ, гэрийн асрамж үйлчилгээ зэрэг багтана. Эдгээр үйлчилгээ нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй, хүчирхийлэлд өртсөн иргэд, шоронгоос суллагдсан, эсвэл согтуурах болон мансуурах донтох өвчтэй иргэд, эдгэшгүй хүнд өвчтэй иргэн, гэр оронгүй иргэн гэх мэт хүн амын бүлэгт чиглэсэн байна.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнүүд дотроос санхүүжилтийн хамгийн их хувийг эзэлдэг үйлчилгээ бол төсөл хэрэгжүүлэх үйлчилгээ юм. Зорилго нь нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай 2 ба түүнээс дээш өрх, иргэд өөрсдийн санаачлагчаар нэгдэн бүлэг болж орлогоо нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлүүлэх зорилгоор төсөл боловсруулан хэрэгжүүлэх нь олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний нэг төрөлд хамрагдана. Иргэдийн ирүүлсэн төслийг амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ. АДЗ-өөр дэмжигдсэн төслийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс хянаж үзээд хэрэгжих магадлалтай бол 1,0 сая хүртэлх төгрөгөөр санхүүжүүлнэ. 2016 онд төсөл хэрэгжүүлэх үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо 30.0 хувийг эзэлж байсан бол 2017 оноос эхлэн тасралтгүй буурах хандлагатай байгаа бөгөөд 2019 онд гэхэд хамрагдсан иргэдийн тоо 8 хүртэлх хувийг эзэлж байна.

Сэргээн засах үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо 2017 оноос эхлэн өмнөх онуудтай харьцуулахад 2-3 дахин өссөн байна. Жишээлбэл 2016 онд 11.9 хувийг эзэлж байсан бол 2018 онд 29.4 хувийг эзэлж байна. Сэргээн засах үйлчилгээ нь хүний алдагдсан эрүүл мэнд, хөдөлмөрлөж аж төрөх чадварыг сэргээж, нийгмийн болон хувийн амьдралд нь идэвхтэй оролцох боломж нөхцөлийг нь бүрдүүлэхэд нийгэм анагаах ухаан, хөдөлмөр сургалт сэтгэл зүйн цогц үйлчилгээ үзүүлдэг бөгөөд сүүлийн жилүүдэд бага насны хүүхдүүд хамрагдах байдал нь өндөр байна.

Түр байрлуулан асрамжлах, өдрийн үйлчилгээнд хамруулах үйлчилгээнүүдэд хамрагдсан иргэдийн эзлэх хувь 2015-2017 онуудын хооронд буурч байсан бол 2018 оноос өсөх хандлагатай байна. 2019 оны байдлаар олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн гуравны нэгийг буюу 30.2 хувийг тус үйлчилгээ бүрдүүлж байна. Энэхүү үйлчилгээ нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэх, хүнд нөхцөлд байгаа хүүхдүүдийн эрхийг хамгаалах, нийгэмшүүлэх, амьдрах ухаанд сургах зэрэг чадваруудыг олгодог байна.

Харин гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах, иргэн түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх; гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах гэсэн 3 төрлийн үйлчилгээнд хамрагдсан хүмүүсийн тоо бусад үйлчилгээнүүдтэй харьцуулахад бага бөгөөд 2019 онд гэхэд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан нийт иргэдийн 9.0 хувийг эзэлж байна.


Хүснэгт 7. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо /2015-2019/

Үйлчилгээний төрөл	2015	2016	2017	2018	2019
<i>Сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх</i>	2 723	2 745	5 769	3 800	4 812
<i>Сэргээн засах үйлчилгээнд хамруулах</i>	985	911	3 840	5 659	3 249
<i>Түр байрлуулан асрамжлах, өдрийн үйлчилгээнд хамруулах</i>	2 223	1 368	2 713	5 435	4 615
<i>Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах</i>	286	102	146	259	252
<i>Иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх;</i>	0	64	0	1 164	172
<i>Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах</i>	0	187	633	580	955
<i>Төсөл хэрэгжүүлэх үйлчилгээ</i>	1 546	2 283	2 394	2 361	1 239
Нийт	7 763	7 660	15 495	19 258	15 294

Эх сурвалж: ХХҮЕГ, НХҮНМС-ын тайлан

Дээрх үйлчилгээний зарцуулсан хөрөнгийн хувьд төсөл хэрэгжүүлэх үйлчилгээ хамгийн өндөр хувийг эзэлж байна. 2016 онд гэхэд нийт зарцуулалтын 73.6 хувийг дангаараа бүрдүүлж байсан бол, 2017 онд 2.5 дахин буурсан буюу 27.4 хувийг бүрдүүлж байна. Иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх үйлчилгээ нь 2015-2017 онуудын хооронд зарцуулалтын хэмжээ болон хамрагдсан иргэдийн тоо бусад үйлчилгээнүүдтэй харьцуулахад бага байсан бол 2018 онд хамрагдсан иргэдийн тоо болон зарцуулсан хөрөнгийн эзлэх хувь өсөж нийт зарцуулсан хөрөнгийн 19.3 хувийг эзэлсэн байна. Мөн сэргээн засах үйлчилгээнд хамруулах үйлчилгээний зарцуулсан хөрөнгийн хувьд 2016 оноос хойш тасралтгүй өсөж байгаа бөгөөд 2017 оны зарцуулсан хөрөнгийн 31.0 хувийг бүрдүүлсэн байна.

Зураг 5. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдэд зарцуулсан хөрөнгө 2015-2019 /үйлчилгээний төрлөөр/



Эх сурвалж: ХХҮЕГ, НХҮНМС-ын тайлан


2.5. Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ

Төрөлжсөн асрамжийн газарт тэжээн тэтгэх хүүхэд, төрөл, садангүй, бие даан амьдрах чадваргүй ганц бие, эсхүл тэжээн тэтгэх үүрэгтэй этгээд нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх чадваргүй болох нь тогтоогдсон бөгөөд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах боломжгүй ахмад настан, мэргэжлийн үйлчилгээ, тусгай нөхцөл шаардагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүнд нөхцөлд байгаа, эсхүл байнгын асрамжид байдаг хөгжлийн бэрхшээлтэй 16 хүртэлх насны хүүхэд, гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийг хүлээн авна. Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ нь дараах төрөлтэй байна. Үүнд:

1. Ахмад настны асрамжийн үйлчилгээ
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамжийн үйлчилгээ
3. Хүнд нөхцөлд байгаа 18 хүртэлх насны хүүхдийн асрамжийн үйлчилгээ
4. Гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийн асрамжийн үйлчилгээ

2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 434 иргэн төрөлжсөн халамжийн үйлчилгээнд хамрагдсан байна. Нийт хамрагдсан иргэдийн 60.0 хувь буюу 259 нь ахмад настан, 40.0 хувь буюу 175 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. Үйлчилгээ үзүүлэгч нийт 12 асрамж үйлчилгээний байгууллага байгаа бөгөөд үүнээс Батсүмбэрийн улсын асрамжийн газар, “Батгэрэлт-ирээдүй” ТББ-ын ХБИ-ийн асрамжийн газруудад хамгийн олон иргэд үйлчүүлдэг байна.

Зураг 5. Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо /2019/



Эх сурвалж: ХХҮЕГ, НХҮНМС-ын тайлан

2.6. Нийгмийн хөгжлийн үйлчилгээ


Боловсролыг дэмжих үйлчилгээ, Эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ, Хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэнд хүнсний бүтээгдэхүүн худалдан авах хүнс тэжээлийн дэмжлэг гэсэн 3 төрлийн үйлчилгээ багтана. Эхний 2 үйлчилгээний хувьд эрх зүйн орчин бүрдэж эхлээгүй байна.

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хувьд:

Нийгмийн халамжийн тухай хуульд заасан нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд чиглэсэн хүнсний эрхийн бичиг олгох үйлчилгээг 2013 оноос эхлэн 21 аймаг, 9 дүүрэгт хэрэгжүүлж байна. ХАХНХ-ын сайдын 2015 оны 02 сарын 03-ний өдрийн А/20 дугаар тушаалаар батлагдсан 240.3176 бүхий босго онооноос доогуур "хүн амын" хамгийн бага хэрэглээтэй хэсэг болох нийт 24 642 өрхийн 135 413 иргэнд хүнсний эрхийн бичгийн олголт хийгдэж байв. Үүнээс нийслэлийн дүүргүүд болон аймгийн төвүүдэд цахим хэлбэрээр, алслагдсан сум сууринд цаасан хэлбэрээр тус тус хүнсний эрхийн бичиг хүлээн авч байна. Нийгэм эдийн засгийн өөрчлөлт, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт зэрэгтэй уялдуулан 2015 оны Хүнсний эрхийн бичгийн үнийг нэмэгдүүлж, хүүхдэд 6500, том хүнд 13000 төгрөгөөр олгож байсан байна. Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ нь 2008 онд засгийн газрын 25 дугаар тогтоолоор эдийн засгийн хямрал, хүнсний бүтээгдэхүүний дутагдлаас үүдэн "Нийгмийн эмзэг бүлэгт хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөр"-ийг анх хэрэгжүүлж эхэлсэн. 2010 онд ХНХЯ, ҮСХ-ны хамтарсан 56/36 тоот тушаалаар "Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох аргачлал" батлагдаж 2013 оны 3 дугаар сарын 1-ээс хүнсний талон олгож эхэлсэн. 2014 оны 12 дугаар сарын 30-нд хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/32 тоот тушаалаар "Хүнсний эрхийн бичиг олгох журам" батлагдсан. Тус журамд 2015, 2017, 2018, 2020, 2021 онуудад нэмэлт өөрчлөлт орсон байна.

2017 онд Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 11 сарын 23- ны өдрийн А/205 тушаалаар Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээний босго оноог 292.5 ба түүнээс доош өрхийн гишүүн иргэнд сард олгох ХЭБ үнийн дүнг нэг хүүхдэд 8000 төгрөгөөр, насанд хүрсэн нэг хүнд 16000 мянган төгрөгөөр⁶ тус тогтоосноор нийт зарцуулсан хөрөнгийн хэмжээ 1.8 дахин нэмэгдэв. Мөн 2018 оны ХНХС-ын 2018 оны А/13 тушаалаар Хүнсний эрхийн бичиг олгох жухам шинэчлэгдсэнтэй холбогдуулан, хамрагдсан өрхийн тоо 2017-2018 оны хооронд 51 577 өрхөөр буурсан үзүүлэлттэй байна. Мөн 2017 оны журмын нэмэлт өөрчлөлттэй холбогдуулан зарцуулсан хөрөнгийн хэмжээ 1.8 дахин өссөн буюу 2018 оны жилийн эцсийн байдлаар 36.2 тэрбум төгрөгийг энэхүү үйлчилгээнд зарцуулсан байна.

Зураг 6. Хүнс тэжээлийн дэмжлэг үйлчилгээнд хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө 2015-2019 тэрбум.төг



Эх сурвалж: ХХҮЕГ, НХҮНМС-ын тайлан

2.7. Алдар цолтой ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт

Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтой ахмад настанд төрөөс олгох нэмэгдлийн тухай хуулиар сар бүр 200,0 мянган төгрөг олгогдоно. Ахмад дайчин, түүнчлэн дайнд оролцож яваад амь үрэгдсэн иргэний эхнэр/ нөхөр/-т сар бүр 200,0 мянган төгрөг, Монгол улсын төрийн шагналт, төрийн соёрхолт, түүнчлэн улсын ударник, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэнд жилд нэг удаа 150,0 мянган төгрөгийн мөнгөн тусламж олгодог. Үүнээс гадна, амралт сувиллын газар амрах эрхийн бичгийн хөнгөлөлт болон орон сууцны хөлс төлөх эсвэл түлшний зардал жилд нэг удаа олгодог.

Алдар цолтой ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт үйлчилгээнд 2019 онд 4 417 иргэн хамрагдсан байна. 2019 оны байдлаар Монгол улсын төрийн шагналт, төрийн соёрхолт, түүнчлэн улсын ударник, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэнд мөнгөн тусламж үзүүлэх үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо хамгийн өндөр жинг эзэлж байна. 2017 онд хамгийн олон хүн буюу 6 584 иргэн хамрагдсан бөгөөд, алдар цолтой хүмүүст орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох үйлчилгээнд хамрагдсан иргэд 62.3 хувийг бүрдүүлсэн байна. Ахмад дайчин, түүнчлэн дайнд оролцож яваад амь үрэгдсэн иргэний эхнэр /нөхөрт/-т сар бүр мөнгөн тусламж үйлчилгээний хамрагдсан иргэдийн тоо тасралтгүй буурч байгаа бөгөөд, 2019 онд гэхэд 177 иргэн хамрагдсан нь 2015 оны хамрагдсан иргэдтэй харьцуулахад 282 иргэнээр буурсан байна.

⁶ <http://ub.hudulmur-halamj.gov.mn/>


Хүснэгт 8. Алдар цолтой ахмад настан үзүүлсэн нэмэгдэл хөнгөлөлтөд хамрагдсан иргэдийн тоо, /2015-2019/

Үйлчилгээний төрөл	2015	2016	2017	2018	2019
Ахмад дайчин, түүнчлэн дайнд оролцож яваад амь үрэгдсэн иргэний эхнэр /нөхөрт/ -т сар бүр мөнгөн тусламж	459	353	301	199	177
Монгол Улсын төрийн шагналт, төрийн соёрхолт, түүнчлэн улсын ударник, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэнд мөнгөн тусламж үзүүлэх	1 985	1 901	872	1 753	2 006
Алдар цолтой хүмүүст нийслэлээс аймагт, аймгаас нийслэлд ирэх, буцах замын зардлыг нэг удаа олгох	172	286	825	580	191
Алдар цолтой хүмүүст дотоодын рашаан сувилалд ирэх, буцах замын зардал, эрхийн бичгийн үнийг жилд нэг удаа нөхөн олгох	408	455	483	399	481
Алдар цолтой хүмүүст орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох	1 764	1 941	4 103	1 964	1 562
Нийт дүн	4 788	4 936	6 584	4 895	4 417

Эх сурвалж: ХХҮЕГ, НХҮНМС-ын тайлан

Дээрх үйлчилгээний зарцуулсан хөрөнгийн хувьд Монгол улсын төрийн шагналт, төрийн соёрхолт, түүнчлэн улсын ударник, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэнд мөнгөн тусламж үзүүлэх үйлчилгээ 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт зарцуулалтын 79.6 хувийг бүрдүүлсэн байна. Алдар цолтой хүмүүст орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох үйлчилгээний зарцуулсан хөрөнгийн хувьд жил бүрийн нийт зарцуулалтын тогтмол 7.5-8.5 хувийг эзэлж байна. Мөн ахмад дайчин, түүнчлэн дайнд оролцож яваад амь үрэгдсэн иргэний эхнэр /нөхөрт/ -т сар бүр мөнгөн тусламж үйлчилгээнд зарцуулж буй мөнгөн тэтгэмжийн хэмжээ жил ирэх тусам буурах хандлагатай байна.

Зураг 7. Алдар цолтой ахмад настан үзүүлсэн нэмэгдэл хөнгөлөлтөд хамрагдсан иргэдэд зарцуулсан хөрөнгө, /2015-2019/ үйлчилгээний төрлөөр,



Эх сурвалж: ХХҮЕГ, НХҮНМС-ын тайлан

2.8. Ахмад настны тусламж, хөнгөлөлт

Ахмад настанд үзүүлэх тусламж хөнгөлөлтийн үйлчилгээнүүдэд протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлт, орон сууцны үнийн хөнгөлөлт, амралт сувиллын үнийн хөнгөлөлт, тээврийн хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнүүд багтана.

Үйлчилгээнүүд дотроос хамгийн их хамрагддаг үйлчилгээнүүд бол протез, ортопедийн үнийн хөнгөлөлт, ахмадын амралт сувиллын эрхийн бичиг, замын зардлын үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнүүд байна. Протез, ортопедийн үнийн хөнгөлөлтөд хамрагдаж байгаа ахмад настны тоо жил ирэх тусам өсөх хандлагатай байгаа бөгөөд 2019 оны байдлаар 64 239 ахмад настан хамрагдсан байна. Эсрэгээрээ Ахмад настан болон хүндэт донорын орон сууц, түлшний хөнгөлөлт үйлчилгээнд хамрагдаж буй иргэдийн тоо жил ирэх тусам буурах хандлагатай байгаа буюу 2015 онтой харьцуулахад 2019 оны жилийн эцсийн байдлаар 1 953 ахмад настанаар буурсан байна.

Хүснэгт 9. Ахмад настанд үзүүлэх дэмжлэг хөнгөлөлтийн үйлчилгээнүүдэд хамрагдсан иргэдийн тоо, /2015-2019/

Үйлчилгээний төрөл	2015	2016	2017	2018	2019
<i>Гар, хөл, шүд/үнэт металлээр хийхээс бусад/-ний протезийн үнийн хөнгөлөлт</i>	26 400	32 377	36 650	40 578	48 213
<i>Ортопедийн үнийн хөнгөлөлт</i>	10 572	9 384	9 309	16 282	16 026
<i>Ахмадын зориулалттай амралт, сувиллын газарт амрах эрхийн бичгийг хөнгөлөлттэй үнээр олгох</i>	37 544	50 054	45 546	50 123	53 875
<i>Ахмад настан болон хүндэт донорын орон сууц, түлшний хөнгөлөлт</i>	9 565	8 765	8 248	7 572	7 612
<i>Магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувиллын замын зардал, эрхийн бичгийн үнийн хөнгөлөлт</i>	20 600	26 867	32 927	31 381	36 436
<i>Нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй ахмад настанд олгох оршуулгын тэтгэмж</i>	45	33	63	217	177
<i>Нийслэлээс 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт оршин суудаг ахмад настанд унааны хөнгөлөлт</i>	2 846	2 617	3 549	3 649	3 759
<i>Бусад</i>	0	0	3	323	0
Нийт	107 572	130 097	136 295	150 125	166 058

Эх сурвалж: ХХҮЕГ, НХҮНМС-ын тайлан

2019 оны жилийн эцсийн байдлаар ахмад настны дэмжлэг, хөнгөлөлт үйлчилгээнд 28.5 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд өмнөх жилүүдтэй харьцуулахад нийт зарцуулалтын дүн тогтмол өссөөр байгаа юм. Протез, ортопедийн үнийн хөнгөлөлт үйлчилгээнд хамрагдаж буй ахмад настны тоо, зарцуулж буй мөнгөн дүн ч тогтмол өссөөр байгаа юм. 2019 оны нийт зарцуулалтад хамгийн өндөр жинг ахмадын зориулалттай амралт, сувиллын газарт амрах эрхийн бичгийг хөнгөлөлттэй үнээр олгох үйлчилгээ эзэлж байгаа бол үүний дараа протез, ортопедийн үнийн хөнгөлөлт, магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувиллын замын зардал, эрхийн бичгийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнүүд орж байна.

Зураг 8. Ахмад настанд үзүүлэх дэмжлэг хөнгөлөлтийн үйлчилгээнүүдэд хамрагдсан иргэдэд зарцуулсан хөрөнгө, /2015-2019/ үйлчилгээний төрлөөр,



Эх сурвалж: ХХҮЕГ, НХҮНМС-ын тайлан

2.9. Ахмад настанд үзүүлэх хүндэтгэл, насны хишиг

Ахмад настанд үзүүлэх хүндэтгэл үйлчилгээ нь жилд 2 удаа ахмад настан тус бүрд 10 000 төгрөг олгодог бол насны хишиг үйлчилгээний хувьд 65-69 настанд 50 000 төгрөг, 70-79 настанд 80 000 төгрөг, 90 ба түүнээс дээш настанд 250 000 төгрөг тус тус олгодог байна. Жил бүрийн цагаан сар, үндэсний их баяр наадмыг тохиолдуулан насны хишиг олгох бөгөөд, насны хишиг олгох журмыг Засгийн газар батална.

2019 оны жилийн эцсийн байдлаар ахмад настанд үзүүлсэн хүндэтгэл үйлчилгээнд 128 052 ахмад настан хамрагдсан бол 2017 онтой харьцуулахад 26 126 ахмад настанаар нэмэгдсэн байна. Харин 2019 оны жилийн эцсийн байдлаар 138 383 ахмад настан насны хишиг авсан бол 2017 онтой харьцуулахад 2 649 ахмад настанаар буурсан байна.


Зураг 9. Ахмад настанд үзүүлэх хүндэтгэл, насны хишиг үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо, /2017-2019/



Эх сурвалж: ХХҮЕГ, НХҮНМС-ын тайлан

Энэхүү 2 үйлчилгээнд хамрагдаж буй иргэдийн тоо харьцангуй ойролцоо боловч нийт зарцуулалтын хэмжээ олгож буй мөнгөн дүнгээс хамааран нэлээд зөрүүтэй харагдаж байна. 2019 оны дүнгээс харахад ахмад настанд үзүүлсэн хүндэтгэл үйлчилгээ нь насны хишиг үйлчилгээнээс 12.7 дахин бага мөнгө зарцуулагдсан байна. 2019 онд Насны хишиг үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоог 2017 онд хамрагдсан иргэдтэй харьцуулахад бага байсан боловч зарцуулсан хөрөнгийн хувьд 1 911.6 сая төгрөгөөр өндөр байна.

Зураг 10. Ахмад настанд үзүүлэх хүндэтгэл, насны хишиг үйлчилгээнд хамрагдсан иргэдэд зарцуулсан хөрөнгө, /2017-2019/, сая төг



Эх сурвалж: ХХҮЕГ, НХҮНМС-ын тайлан

2.10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлт

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх тусламж хөнгөлөлтөд орон сууцны хөлс төлөх эсвэл түлш худалдан авахад зориулж жилд нэг удаа олгох мөнгөн тусламж, нөхөн сэргээх болон поротез, ортопед, тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд ирж очих унааны зардал, жилд нэг удаа эмчилгээний зориулалтаар амралт сувилалд явбал нэг талын тээврийн зардал болон эмчилгээний төлбөрийн хөнгөлөлт, хараагүй иргэдэд суурин утасны төлбөрийн хөнгөлөлт зэрэг орно.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлт үйлчилгээнүүд дотроос хамгийн олон иргэн хамрагддаг үйлчилгээ бол байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны ХБХ, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан ХБИ, бүрэн хэлгүй, дүлий иргэн орон сууц, түлшний хөнгөлөлтийн үйлчилгээ бөгөөд 2019 онд нийт хамрагдсан иргэдийн 34.6 хувийг, нийт зарцуулсан хөрөнгийн 27.2 хувийг бүрдүүлж байна. Үүний дараа ХБХ, НДС-аас хөнгөлөлт авах эрх үүсээгүй ХБИ-ий ортопед, тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээ орж байгаа бөгөөд 2019 оны байдлаар 10 806 иргэнд 1 674.8 сая төгрөг зарцуулсан байна. Нийгмийн даатгалын сангаас хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэд энэхүү үйлчилгээнүүдэд голчлон хамрагдаж байгаа бөгөөд нийт зарцуулж буй мөнгөн тэтгэмжийн хэмжээ 2019 оны байдлаар 11 496.2 сая төгрөг байна.

Хүснэгт 10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлт үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо, тэдгээрт зарцуулсан хөрөнгө, /2015-2019/ үйлчилгээний төрлөөр,

Үйлчилгээний төрөл	Хэмжих нэгж	2015	2016	2017	2018	2019
Бүрэн хараагүй ХБИ түлшний хөнгөлөлт	хүн	2 575	3 853	3 435	5 259	3 573
	сая.төг	352.2	545.5	600.0	966.7	524.6
Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны ХБХ, хөдөлмөрийн чадвараа алдсан ХБИ, бүрэн хэлгүй, дүлий иргэн орон сууц, түлшний хөнгөлөлт	хүн	19 932	19 244	16 506	16 516	21 906
	сая.төг	2 804.3	2 771.2	2351.4	2 479.4	3 137.2
Одой иргэний орон сууцны түлшний хөнгөлөлт	хүн	263	188	184	174	150
	сая.төг	39.3	26.4	26.3	191 0	21.4
18 хүртэлх насны ХБХ-ийн дотоодод хийлгэсэн протезын үнийн хөнгөлөлт	хүн	3 875	101	238	573	227
	сая.төг	1 050.0	27.9	48.4	454.0	56.5
НДС-аас хөнгөлөлт авах эрх үүсээгүй, ХБИ-ий протезийн үнийн хөнгөлөлт	хүн	4 312	9 320	7 889	5 313	5 628
	сая.төг	1 351.2	1 979.4	1774.9	1 467.5	1 231.1
ХБХ, НДС-аас хөнгөлөлт авах эрх үүсээгүй ХБИ-ий ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлт	хүн	9 450	12 624	10 266	9 220	10 806
	сая.төг	1 678.9	2 234.7	1668.5	1 816.2	1 647.8
ХБХ болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн унааны зардлын хөнгөлөлт	хүн	2 076	2 228	2 453	3 546	3 762
	сая.төг	418.1	460.8	565.7	685.0	795.0
Дотоодын рашаан сувилалд сувилуулах шаардлагатай ХБХ, НДС-аас хөнгөлөлт авах эрх үүсээгүй ХБИ-д ирж, очих унааны, ор хоногийн зардлын хөнгөлөлт	хүн	3 223	3 486	3 967	3 577	6 492
	сая.төг	602.8	640.8	937.9	966.5	1 628.4
ХБХ-ийн болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэний нэг хүүхдийн цэцэрлэгийн хоолны төлбөрт хөнгөлөлт үзүүлэх	хүн	14	62	143	235	30
	сая.төг	1.7	13.9	34.5	87.2	8.0
Насанд хүрсэн бүрэн хараагүй, сонсгоогүй, хэл ярианы бэрхшээлтэй хүний харилцаа холбооны зардлын хөнгөлөлт	хүн	4 230	2 185	2 637	3 215	6 114
	сая.төг	447.5	461.1	518.0	73.5	815.6
Алслагдсан газарт оршин суудаг ХБИ нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд унааны зардал олгох	хүн	1 240	1 564	1 747	2 111	3 144
	сая.төг	182.2	204.6	194.8	472.8	664.2
Хараагүй хүний брайлын үсгээр бичсэн захидал, ил захидал, брайль хэвлэл дотоодод үнэ төлбөргүй хүргүүлэх	хүн	0	1	495	11	8
	сая.төг	0	0.1	144.1	2.2	0.9
Бүрэн хараагүй хүн эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр эмчлүүлэх, рашаан сувилалд сувилуулах замын зардлын хөнгөлөлт	хүн	2	54	62	21	241
	сая.төг	0.07	9.3	10.3	2.6	47.8
ХБХ нь хүүхдийн зусланд амарвал эрхийн бичгийн үнийн хөнгөлөлт	хүн	62	124	31	155	175
	сая.төг	3.3	8.4	3.9	31.9	40.6
ХБИ болон ХБХ нас барвал түүний оршуулгын зардлын мөнгөн тусламж	хүн	126	226	506	657	870
	сая.төг	59.0	166.5	521.3	605.0	869.5
ХБИ олимп, тивийн наадам, дэлхийн зэрэглэлийн тэмцээнд оролцож медаль хүртсэн тохиолдолд мөнгөн тусламж	хүн	12	32	56	14	3
	сая.төг	30.9	77.0	169.0	88.1	6.3
Хараагүй хүнд зориулсан брайль болон томруулсан үсэгтэй ном, сурах бичиг, сонин сэтгүүл хэвлэх зардлыг нийгмийн халамжийн сангаас гаргах	хүн	10	170	20	12	4
	сая.төг	68.8	62.1	6.0	11.7	0.8
Нийт дүн	хүн	51 402	55 462	50 635	50 609	63 133
	сая.төг	9 091.0	9 689.7	9 575.4	11 064.3	11 496.2

Эх сурвалж: ХХҮЕГ, НХҮНМС-ын тайлан

2.11. Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх эцэгт олгох тэтгэмж (мөнгөн тэтгэмж)

Жирэмсэн эхийн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж, Ихэр хүүхдийн тэтгэмж, 3 ба түүнээс дээш тооны 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/-ийн тэтгэмж гэсэн үндсэн 4 төрлийн тэтгэмж байна. Асаргааны тэтгэмж болон, жирэмсэн эхийн тэтгэмжийг сар бүр олгож байгаа бол бусад тэтгэмжүүдийн олгох давтамж жил болон улирлаар ялгаатай байдаг. Мөн Эхийн алдар 1, 2 дугаар зэргийн одонтой эхчүүдэд олгох мөнгөн тусламж үйлчилгээг энэ бүлэгт авч үзсэн болно.

Үйлчилгээнүүдэд 2019 оны байдлаар 517 337 иргэн хамрагдаж 144 769.5 сая төгрөг зарцуулжээ. Нийт зарцуулалтын 63.8 хувийг 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж бүрдүүлж байгаа бол дараагаар нь одонтой эхчүүдэд олгох мөнгөн тэтгэмж 20.2 хувь байна. Жирэмсэн эхийн тэтгэмжид хамрагдаж буй иргэдийн тоо тогтмол буурч байгаа бөгөөд 2016 онтой харьцуулахад 92 283 иргэнээр буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 11. Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх эцэгт олгох тэтгэмж үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо, тэдгээрт зарцуулсан хөрөнгө, /2015-2019/ үйлчилгээний төрлөөр,

Үйлчилгээний төрөл	Хэмжих нэгж	2015	2016	2017	2018	2019
Эхийн алдар 1, 2 дугаар зэргийн одонтой эхчүүдэд олгох мөнгөн тусламж	хүн	209 510	213 505	241 635	218 677	223 250
	сая.төг	28 360.4	28 526.4	28 635.6	28 940.9	29 291.2
Жирэмсэн эхийн тэтгэмж	хүн	92 291	173 908	128 008	83 386	81 625
	сая.төг	38 743.8	36 918.0	35 171.6	14 090.3	13 315.6
0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж	хүн	-	-	-	195 018	204 493
	сая.төг	-	-	-	91 542.0	92 254.8
3 болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	хүн	-	-	-	8 098	6 998
	сая.төг	-	-	-	5 228.0	7 905.9
4 хүртэлх насны хоёр ихэр хүүхэдтэй иргэн	хүн	-	-	-	893	971
	сая.төг	-	-	-	1 746.0	1 992.0
4 хүртэлх насны 3 болон түүнээс дээш ихэр хүүхэдтэй иргэн	хүн	-	-	-	13	0
	сая.төг	-	-	-	92.6	0.0
Нийт дүн	хүн	301 801	387 413	369 643	506 085	517 337
	сая.төг	67 104.2	65 444.4	63 807.2	141 639.8	144 759.5

Эх сурвалж: ХХҮЕГ, НХҮНМС-ын тайлан

2.12. Хүүхдийн мөнгөн тэтгэмж

Хүүхдийн мөнгөн тэтгэмж үйлчилгээ нь өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрагдсан өрхийн 0-18 хүртэлх насны хүүхэд, эсхүл түүнийг төлөөлөх хууль ёсны эрх бүхий МУ-н иргэнд олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ. Хүүхдийн мөнгө олгох арга хэмжээг “Нийгмийн халамжийн тухай хууль”-ийн 13 дугаар зүйлийн 13.1.5-д нийгмийн халамжийн тэтгэмжийн нэг төрөл болгон хуульчилж, хүүхдийн мөнгөн тэтгэмж хэлбэрээр олгох болсон. “Хүний хөгжил сангийн тухай хууль” 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр хүчингүй болсонтой холбогдуулан Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар “Хүүхдийн мөнгө олгох журам”-ыг баталсан байна. Хүүхдийн мөнгө олгох журамд орсон гол өөрчлөлт нь санхүүжилтийн эх үүсвэр юм. Өмнө нь хүүхдийн мөнгийг Хүний хөгжил сангаас санхүүжүүлдэг байсан бол шинэ журмаар нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлэхээр зохицуулсан. Энэхүү хуулийн зохицуулалтаас хойш Нийгмийн Халамжийн Сангийн зарцуулалт нэлээдгүй өндөр хувиар өсөж байна.

2012 онд 20 000 төгрөг нь \$14-той тэнцдэг байсан бол өнөөдөр \$7 тэнцэх болсон. Өнөөдөр 20 000 төгрөгөөр иргэдийн худалдан авч байгаа бараа бүтээгдэхүүний тоо хэмжээ

2021 оныхтой харьцуулахад огцом буурсан.⁷ 2019 оны байдлаар хүүхдийн мөнгөн тэтгэмж үйлчилгээнд зарцуулсан хөрөнгө нийгмийн халамжийн сангийн зардлын 34 хувийг дангаараа бүрдүүлж байгаа буюу нийт 1 000 557 мянган хүүхэд хамрагдсан байна. 2016 болон 2018 онуудад хамрагдсан хүүхдийн тоо болон зарцуулсан хөрөнгийн хэмжээнд бууралтууд ажиглагдсан бол 2019 оноос буцаад өсөх хандлагатай байна.

Зураг 11. Хүүхдийн мөнгөн тэтгэмж үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн тоо, тэдгээрт зарцуулсан хөрөнгө /2015-2019/ сая.төг




Эх сурвалж: ХХҮЕГ, НХҮНМС-ын тайлан

2.13. Цаатан иргэний тэтгэмж

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 42 дугаар зарлигийн 1.1 дэх хэсэгт “Цаатан иргэдийн амьдралын нөхцлийг сайжруулах зорилгоор тайгад амьдардаг 18 хүртэлх насны цаатан хүүхдэд тухайн бүс нутагт тогтоосон амьжиргааны доод түвшингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний, насанд хүрсэн иргэнд амьжиргааны доод түвшингийн хэмжээгээр сар бүр мөнгөн тэтгэмж олгох” чиглэлээр арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газарт чиглэл үүрэг болгосны дагуу батлагдан 2018 оны 6-р сар хүртэл үргэлжилсэн. 2018 оноос эхлэн энэхүү үйлчилгээнд хамруулах иргэдийг амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлж, Засаг даргын захирамжаар баталгаажуулж байхаар болсон. Цаатан иргэний тэтгэмж үйлчилгээнд хамрагдаж буй иргэдийн тоо 2015 оноос хойш харьцангуй тогтвортой байгаа бөгөөд 2019 оны жилийн эцсийн байдлаар 368 цаатан иргэн хамрагдсан байна. Зарцуулсан хөрөнгийн хувьд 665.8 сая төгрөг зарцуулсан нь өмнөх оны мөн үеэс 100.6 сая (17.7) хувиар өссөн байна.

Зураг 12. Цаатан иргэний тэтгэмжид хамрагдсан иргэдийн тоо, тэдгээрт зарцуулсан хөрөнгө, /2015-2019/ сая.төг



Эх сурвалж: ХХҮЕГ, НХҮНМС-ын тайлан

⁷ unicef.org/mongolia/mn

Бүлэг III

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН
ХӨТӨЛБӨРҮҮДЭД ҮЗҮҮЛЭХ “КОВИД-19
ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨЛӨЛ


III БҮЛЭГ. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ХӨТӨЛБӨРҮҮДЭД ҮЗҮҮЛЭХ “КОВИД-19 ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨ”

Коронавируст халдварын цар тахал худалдаа, эдийн засгийн үйл ажиллагаанд мэдэгдэхүйц сөрөг нөлөө үзүүлж, орлого ялангуяа, хөдөлмөр эрхлэлт (цалин, хөлстэй хөдөлмөр эрхлэлт болон хувиараа хөдөлмөр эрхлэлт)-ийн орлого буурахад нөлөөлсөн.

Ковид-19 цар тахлын эдийн засагт үзүүлж буй цочир нөлөө дэлхийн хүн амд өргөн хүрээгээр нөлөөлж, улс орнуудын нийгмийн хамгааллын системийн бэлэн байдлыг шалгаж байна. Монгол Улсын Засгийн газар өрх айл бүрийн түвшинд цар тахлын эрсдэлийг бууруулах зорилгоор багц арга хэмжээ авч хэрэгжүүлснээр нийгмийн халамжид хамрагддаг бүлэг төдийгүй нийгмийн бусад бүлгийн хүмүүсийг ч хамруулсан юм. 2020 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн “Коронавируст халдварын цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих нийгмийн хамгааллын зарим арга хэмжээний тухай” 167-р тогтоол гарсан.

Нийгмийн халамжийн сангийн нийт зарцуулалтын хэмжээ 2020 оны жилийн эцсийн байдлаар 1 586.9 тэрбум төгрөг байсан нь өмнөх оны мөн үеэс 2.35 дахин өссөн буюу цэвэр өсөлтийн хувь 135.6 хувь байна. 2017 онд нийгмийн халамжийн сангийн зардал 526.5 тэрбум төгрөгт хүрч байсантай харьцуулахад мөн л 3 дахин өсжээ.


Зураг 13. Нийгмийн халамжийн сангийн зарцуулалтын өөрчлөлт /2012-2020/, тэрбум.төг



Улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2020 онд 14.0 их наяд төгрөг болж, өмнөх оноос 2.3 (19.7%) их наяд төгрөгөөр өссөн байна. Зарлагын өсөлтөд урсгал зардал 2.6 (32.1%) их наяд төгрөг, хөрөнгийн зардал 35.0 (1.2%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ. Харин эргэж төлөгдөх цэвэр зээл 378.9 (91.0%) тэрбум төгрөгөөр буурсан байна⁸. Харин улсын нэгдсэн төсвийн зарлагад нийгмийн халамжийн сангийн зарцуулалтын эзлэх хувь 2020 онд 11.4 хувьд хүрсэн буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.6 пунктээр өссөн байна.


⁸ Эх үүсвэр: ҮСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020

Зураг 14. Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлагад нийгмийн халамжийн сангийн зарцуулалтын эзлэх хувийн өөрчлөлт /2012-2020/



Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ 2020 оны жилийн эцсийн байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.6 дахин цэвэр бууралт үзүүлсэн байна. Монгол улсын ДНБ-д эзлэх нийгмийн халамжийн сангийн зарцуулалтын эзлэх хувь 1.8-1.9 пунктын хооронд сүүлийн 3 жилүүдийн хооронд хэлбэлзэж байв. Харин “Ковид-19” цар тахлаас шалтгаалан нийгмийн халамжийн сангийн зарцуулалт нэмэгдсэн 2020 онд ДНБ-д эзлэх нийгмийн халамжийн сангийн зарцуулалтын эзлэх хувь 4.2 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 2.3 дахин нэмэгджээ.

Зураг 15. Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүнд нийгмийн халамжийн сангийн зарцуулалтын эзлэх хувийн өөрчлөлт /2012-2020/



3.1 Нийгмийн халамжийн нийт хөтөлбөрүүдэд гарсан өөрчлөлт

Нийгмийн халамжийн сангаас 2020 онд 2.6 (давхардсан тоогоор) сая хүнд 1.6 их наяд төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлт олгосон нь өмнөх оноос нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид 194.6 (8.2%) мянгаар, үйлчилгээнд олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн хэмжээ 912.5 (2.4 дахин) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

“Ковид-19”-оос шалтгаалан олгож буй мөнгөн дүнд өөрчлөлт орсон үйлчилгээнүүдийн хувьд хүүхдийн мөнгөн тэтгэмж нийт өөрчлөлтийн голлох хувийг эзэлж байна. Харин мөнгөн дүнд өөрчлөлт ороогүй үйлчилгээнүүд дотроос олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо 28.7 хувиар, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт 14.5 хувиар буурсан байгаа бол алдар цолтой ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт үйлчилгээнд хамрагдсан ахмад настны тоо 24.6 хувиар өссөн байна. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо жилийн эцсийн байдлаар буурсан байгаа нь олон нийтийн хөл

хорио тогтоосноос шалтгаалж сургалт зохион байгуулах, сэргээн засах үйлчилгээнд хамруулах, зөвлөгөө өгөх зэрэг үйлчилгээнүүдийг явуулах боломжгүй болсонтой холбоотой гэж үзэж байна. Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж үйлчилгээнд зарцуулж буй мөнгөн дүн 35.2 хувиар, цаатан иргэний тэтгэмж 13.7 хувиар өссөн бол ахмад настны дэмжлэг хөнгөлөлт үйлчилгээнд зарцуулж буй мөнгөн дүн 5.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 12. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид, тэдгээрт олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн хэмжээ төрлөөр, /2020/

Үйлчилгээний төрөл	Нийгмийн халамж хүртэгсэд		Нийт зарцуулалт	
	Мян.хүн	Жилийн өсөлтийн хувь	сая төгрөг	Жилийн өсөлтийн хувь
Нийт				
Нийгмийн халамжийн тэтгэвэр	60 359	-3.6	162 897.2	46.0
Нийгмийн халамжийн асаргааны тэтгэмж	64 769	-0.5	58 555.8	22.8
Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	58 130	8.2	40 897.6	35.2
Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ	446	2.7		
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	53 931	-14.5	10 836.1	-5.74
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	10 906	-28.7	1 746.5	2.94
Ахмад настанд үзүүлсэн хүндэтгэл насны хишиг	247 753	-0.7	24 606.8	4.8
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	264 422	-0.4	55 451.6	54.8
Алдар цолтой ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	5 504	24.6	5 141.9	0.42
Ахмад настны дэмжлэг хөнгөлөлт	158 064	-4.8	26 809.1	-5.9
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх эцэгт олгох тэтгэмж	523 801	1.2	146 037.1	0.8
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	1 186 289	18.5	1 053045.7	358.6
Цаатан иргэний тэтгэмж	397	7.8	745.8	13.7

Эх сурвалж: ХХҮЕГ, НХҮНМС-ын тайлан

3.2 Нийгмийн халамжийн тэтгэвэрт гарсан өөрчлөлт

Нийгмийн халамжийн 4 төрлийн тэтгэврийг “Ковид-19”-оос шалтгаалан зарцуулж буй мөнгөн дүнг 288 000 төгрөг болгоод байгаа билээ. 2020 оны жилийн эцсийн байдлаар 60 359 иргэн хамрагдсан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.6 хувиар буурсан буюу энэхүү үйлчилгээнд хамрагдалтын тоо харьцангуй тогтвортой байна. Үйлчилгээнүүдээр задлан харвал ахмад настны тэтгэвэр авч байгаа иргэд 7.2 хувиар өссөн бол хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр 4.4 хувиар, 16 насанд хүрсэн одой иргэний тэтгэвэр 6 хувиар тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийн тэтгэвэр 3.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 13. Нийгмийн халамжийн тэтгэврийн үйлчилгээнүүдэд хамрагдсан иргэдийн өөрчлөлт /2019-2021/


Нийгмийн халамжийн тэтгэвэр	2019 II	2019 IV	2020 II	2020 IV	Өсөлтийн хувь	2021 II
Ахмад настны тэтгэвэр	2 689	3 595	3 411	3 855	7.2	3 726
16 насанд хүрсэн одой иргэний тэтгэвэр	113	116	106	109	-6	105
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	37 417	42 468	37 402	40 569	-4.4	39 222

Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд	14 525	16442	14 688	15 807	-3.8	14 661
Өрх толгойлсон эх, эцгийн тэтгэвэр	17	19	16	19	0	10
Нийт	54 761	62 640	55 623	60 359	-3.6	57 724

Эх сурвалж: ХХҮЕГ, НХҮНМС-ын тайлан

2020 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн халамжийн тэтгэвэрт 162 897 сая төгрөг зарцуулсан нь өмнөх оны мөн үеэс 1.5 дахин нэмэгдсэн байна. Нийт нэмэгдсэн мөнгөн дүн нь 912.5 тэрбум төгрөгийн 5.6 хувийг эзэлж байгаа буюу 51.3 тэрбум төгрөгийг “Ковид-19” цар тахлын дараа нэмж санхүүжүүлсэн байна. Үйлчилгээ тус бүрээр задалж харвал ахмад настны тэтгэвэр 1.7 дахин, одой иргэний тэтгэвэр 1.4 дахин, ХБИ-ний тэтгэвэр 1.4 дахин, тэжээгч нь нас барсан хүүхдийн тэтгэвэр 1.3 дахин, өрх толгойлсон эх эцгийн тэтгэвэр 1.2 дахин нэмэгдсэн байна.

Зураг 16. Нийгмийн халамжийн тэтгэврийн үйлчилгээнүүдэд зарцуулсан хөрөнгийн өөрчлөлт /2019-2020/ сая.төг



Эх сурвалж: ХХҮЕГ, НХҮНМС-ын тайлан


3.3 Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд гарсан өөрчлөлт

Хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн/иргэнд олгож байгаа хүнсний бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичгийн үнийн дүнг нэмэгдүүлж 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс сар бүр нэг хүүхдэд 16 000 (арван зургаан мянган) төгрөг, насанд хүрсэн нэг гишүүнд 32 000 (гучин хоёр мянган) төгрөг 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд олгох⁹: 2021 оны 6 дугаар сарын 25-нд энэхүү журмыг дахин шинэчлэн баталж, хүүхдэд 8000 /найман мянган/ төгрөгөөр, насанд хүрсэн нэг гишүүнд 16000 /арван зургаан мянган/ төгрөгөөр тогтоосон билээ. Мөн энэхүү үйлчилгээг хүргэхдээ улсын хэмжээнд гэрээ байгуулж, тендерт ялсан 800 орчим дэлгүүрээр дамжуулан 10 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг зорилтот өрхөд хүргэдэг байсныг 2021 оны 5 дугаар сараас зогсоон, улсын хэмжээнд НӨАТ-ын баримт буюу е-баримт олгодог 235 мянга орчим ААН, зах, бөөний төвөөр үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн байна.

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 2020 оны жилийн эцсийн байдлаар 264 422 иргэн хамрагдсан нь мөн оны өмнөх үетэй харьцуулахад 22 073 иргэнээр (9.1 хувь) нэмэгдсэн байна. Харин хагас жилийн байдлаар харьцуулбал 2 985 иргэнээр (1.2 хувь) буурсан байна. 2021 оны хагас жилийн байдлаар энэхүү үйлчилгээнд 226 302 иргэн хамрагдсан нь мөн оны өмнөх үетэй харьцуулахад 16 274 иргэнээр (6.7 хувь) буурсан үзүүлэлттэй байна.

ХНХЯ-наас дэвшүүлсэн “Халамжаас Хөдөлмөрт шилжих” зорилгын хүрээнд 2021 оны 6 сарын 25 өдрийн А/103 тоот тушаалаар батлагдсан журмын шинэчлэлээр үйлчилгээнд хамрагдаж буй өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай боловч хөдөлмөр эрхлээгүй иргэн нь аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, хөдөлмөрийн биржид ажил хайгч иргэнээр бүртгүүлсэн байх бөгөөд тухайн байгууллагуудаас иргэнд 2 буюу түүнээс дээш ажлын байранд зуучлахад ажил эрхлэхээс татгалзсан бол хүнсний эрхийн бичиг олголтыг зогсоох арга хэмжээ авахаар зааж өгсөн. Энэхүү журмын шинэчлэлийн дагуу хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдаж буй иргэдийн тоо 2021 оны 6-р сараас эхлэн тасралтгүй буурч 7 болон 8,9-р саруудад 5 766 өрх хасагдсан бөгөөд, Хэнтий аймгийн Баян-Овоо сум анхны хүнсний талонгүй сум, Баянгол дүүргийн 2-р хороо анхны хүнсний талонгүй хороо гэж зарлаад байгаа юм.

Зураг 17. Хүнс тэжээлийн дэмжлэг үйлчилгээнд хамрагдсан иргэдийн өөрчлөлт /2019-2021/




Эх сурвалж: ХХҮЕГ, НХҮНМС-ын тайлан

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 2020 оны жилийн эцсийн байдлаар 55.4 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 19.6 тэрбум (54.7) хувиар нэмэгдсэн байна. “Ковид-19” цар тахлын үед нэмэгдсэн нийт 912.5 тэрбум төгрөгийн 2.1 хувийг хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний нэмэгдэл эзэлж байна. Хүнс тэжээлийн дэмжлэг

⁹ МУ-ын Засгийн газрын 126-р тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон.

үйлчилгээ нь орлого дахин хуваарилалтыг хамгийн сайн хийдэг бодлого ч харьцангуй бага төсөвтэй, бага цар хүрээг хамарсан байна. Хагас жилийн байдлаар харьцуулан харвал 7.3 тэрбум (46.2) хувиар нэмэгдсэн бол 2021 оны хагас жилтэй харьцуулахад 6.5 тэрбум (28.1) хувиар буурсан байна.

Зураг 18. Хүнс тэжээлийн дэмжлэг үйлчилгээнд хамрагдсан иргэдэд зарцуулсан хөрөнгийн өөрчлөлт, /2019-2021/ тэрбум.төг



Эх сурвалж: ХХҮЕГ, НХҮНМС-ын тайлан


3.4 Хүүхдийн мөнгөн тэтгэмж үйлчилгээнд гарсан өөрчлөлт

18 хүртэлх насны хүүхэд бүрт олгож байгаа хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлж 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд сар бүр 100 000 (нэг зуун мянган) төгрөг олгох¹⁰. Энэхүү арга хэмжээ 2022 онд ч дахин үргэлжлүүлэн хэрэгжиж 100 000 төгрөгөөр үргэлжлүүлэх олгох шийдвэр гараад байгаа билээ. Мөн хүүхдийн мөнгөн тэтгэмжийг өрхийн босго оноог харгалзан үзэж олгодог байсан бол 2020 оноос дагуу Монгол улсын харьяат 18 хүртэлх насны бүх хүүхдэд олгох болсноор хамрагдаж буй хүүхдийн тоо өссөн юм. Хүүхдийн мөнгийг олгодог тогтолцоотой байснаар ЗГ-с цар тахлын үед нийт хүүхэдтэй өрхийн 98% цаг алдалгүй хүрч мөнгөн тусламжийг хамгийн үр дүнтэй хүргэж чадсан.

“Ковид-19” цар тахал гарахаас өмнө буюу 2019 оны жилийн эцсийн байдлаар хүүхдийн мөнгөн тэтгэмж үйлчилгээнд 1 000 557 хүүхэд хамрагдсан бол 2020 оны хагас жилийн байдлаар 1 161 679 хүүхэд хамрагдаж 16.1 хувиар өссөн байна. 2020 оны жилийн эцсийн байдлаар 1 186 289 хүүхэд хамрагдсан нь мөн оны өмнөх үетэй харьцуулахад 185 732 (18.5) хувиар нэмэгдсэн байна. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 100 000 төгрөг болгон нэмэгдүүлсэнтэй холбогдуулан хүүхдийн мөнгөн тэтгэмждээ бүрэн хамрагдах, гадаадад байгаа хүүхдүүд хүртэл хамрагдах сонирхол ихэссэн байна.

¹⁰ МУ-ын Засгийн газрын 248-р тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон.

Зураг 19. Хүүхдийн мөнгөн тэтгэмж үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн өөрчлөлт /2019-2021/




Эх сурвалж: ХХҮЕГ, НХҮНМС-ын тайлан

Хүүхдийн мөнгийг сар бүр тогтмол олгосноор хүүхэдтэй өрхүүд баталгаат орлоготой болж, хэрэглээгээ төлөвлөх, зохицуулах боломжийг олгож байна. Өрхүүдэд олгож байгаа мөнгөн тэтгэмж эргээд эдийн засгийн эргэлтэд орж өсөлтийг нэмэгдүүлдэг бөгөөд мөнгөн тэтгэмж хэлбэрээр өрхүүдэд олгосон \$1 бүр эдийн засагт \$1.3-\$2.5 өгөөж авчирдгийг нотолсон.¹¹

Хүүхдийн мөнгөн тэтгэмж үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо болон нийт цар хүрээний хувьд маш том хөтөлбөр бөгөөд ядуурлыг бууруулахад чиглэсэн хамгийн сайн шийдвэр байж чадсан. 2020 оны жилийн эцсийн байдлаар 1 053.0 тэрбум төгрөгийг зарцуулсан нь мөн оны өмнөх үеэс 823.4 тэрбум төгрөгөөр (4.6) дахин нэмэгдэж нийгмийн халамжийн сангийн зарцуулалтыг маш ихээр нэмэгдүүлэв. “Ковид-19” цар тахлын үед нэмэгдсэн нийт 912.5 тэрбум төгрөгийн 90 хувийг хүүхдийн мөнгөн тэтгэмж үйлчилгээний нэмэгдэл эзэлж байна.

Зураг 20. Хүүхдийн мөнгөн тэтгэмж үйлчилгээнд хамрагдсан хүүхдүүдэд зарцуулсан хөрөнгийн өөрчлөлт, тэрбум.төг /2019-2021/



Эх сурвалж: ХХҮЕГ, НХҮНМС-ын тайлан

¹¹ <https://www.unicef.org/mongolia/mn>


3.5 Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн мөнгөн тэтгэмжийн үйлчилгээ

“Ковид-19 цар тахлын” үед Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийгмийн халамжийн тэтгэврийн үйлчилгээнүүдтэй адил хэмжээнд нэмэгдүүлж 288 000 төгрөг болгоод байгаа билээ. 2020 оны жилийн эцсийн байдлаар 11 195 хүүхэд энэ үйлчилгээнд хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 4.2 хувиар буурсан бол олгож буй нийт мөнгөн тэтгэмж өмнөх оны мөн үеэс 1.54 дахин нэмэгдсэн буюу 54.9 хувиар нэмэгдсэн байна. Хамрагдсан хүүхдийн тоо буурсан шалтгаан нь “Ковид-19”-ын үеийн хөл хориотой холбоотойгоор эмчийн магадлалын комиссоор байнгын асаргаатай хүүхдүүд орж амжаагүй байх магадлалтай байна.

2020 оны хагас жилээр энэхүү үйлчилгээнд 10 066 хүүхэд хамрагдаж 12.3 тэрбум төгрөг зарцуулсан нь өмнөх оны мөн үеэс 159 хүүхэд (1.6) хувиар нэмэгдэж зарцуулалтын хэмжээ 3.1 тэрбум (33.6) хувиар нэмэгдсэн байна. Харин 2021 оны хагас жилийн байдлаар 11 494 хүүхэд хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 1 428 хүүхэд (14.1) хувиар нэмэгдэж зарцуулалтын хэмжээ 4.6 тэрбум (37.3) хувиар нэмэгдсэн байна.

“Ковид-19” цар тахлын үед нэмэгдсэн нийт 912.5 тэрбум төгрөгийн 1.1 хувь (10.5) тэрбум төгрөгийг байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн мөнгөн тэтгэмж үйлчилгээний нэмэгдэл эзэлж байна.

Зураг 21. Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдэд олгож буй мөнгөн тэтгэмжид хамрагдаж буй хүүхдийн тоо болон зарцуулсан хөрөнгийн өөрчлөлт /2019-2021/ тэрбум.төг



Эх сурвалж: ХХҮЕГ, НХҮНМС-ын тайлан

3.6 Өрхийн орлогыг хамгаалсан байдал

Нийгмийн халамжийн сангийн өсөлт буюу үйлчилгээнүүдийн үнийг дүнг нэмсэн байдал нь хэр үр дүнтэй байсан бэ гэдгийг харж болохуйц нэг үзүүлэлт нь өрхийг орлогыг хамгаалсан байдал юм. “Ковид-19” цар тахлаас шалтгаалан цалингийн орлого буурсан өрхүүдэд өрхийн орлогыг хамгаалах чухал нэг хүчин зүйл бол тэтгэвэр тэтгэмжийн орлогын нэмэгдэл байх ёстой.

Тэтгэвэр, тэтгэмжийн орлогыг төрлөөр нь задалж харвал, 2020 онд өмнөх оноос улсын дунджаар нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогод өндөр насны тэтгэврийн эзлэх хувь 0.6 пунктээр, хүүхдийн мөнгөний эзлэх хувь 2.1 пунктээр, жирэмсэн болон амаржсан, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжийн эзлэх хувь 0.4 пунктээр нэмэгдсэн байна.

Байршлаар харвал хотын бүсэд өндөр настны тэтгэврийн эзлэх хувь 0.2 пунктээр, хүүхдийн мөнгөний эзлэх хувь 2 пунктээр, жирэмсэн болон амаржсан, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжийн эзлэх хувь 0.4 пунктээр нэмэгдсэн байна. Харин хөдөө орон нутгийн хувьд өндөр настны тэтгэврийн эзлэх хувь 1.8 пунктээр, хүүхдийн мөнгөний эзлэх хувь 2.7 пунктээр, ХБИ-ий тэтгэвэр 0.2 пунктээр, жирэмсэн болон амаржсан, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжийн эзлэх хувь 0.3 пунктээр нэмэгдсэн байна.

Хөдөө орон нутгийн хувьд тэтгэвэр тэтгэмжийн орлогуудын эзлэх хувь хотын бүстэй харьцуулахад илүү өндөр өсөлтийг үзүүлсэн байна. Жишээлбэл хөдөө орон нутагт амьдардаг өрхийн хүүхдийн мөнгөний эзлэх хувь хотын өрхүүдээс 1.4 пунктээр өндөр байна.

Хүснэгт 14. Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогод тэтгэвэр, тэтгэмжийн орлогын эзлэх хувийн өөрчлөлт, тэтгэвэр тэтгэмжийн төрлөөр /2019-2020/


Тэтгэвэр тэтгэмжийн төрлүүд,	Улсын дундаж		Хот		Хөдөө	
	2019	2020	2019	2020	2019	2020
Өндөр насны тэтгэвэр	12.2	12.8	12	12.2	13	14.8
Хүүхдийн мөнгө	1.8	3.9	1.6	3.6	2.3	5
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	2.1	2	2	1.8	2.5	2.7
Жирэмсэн болон амаржсан 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж	0.7	1.1	0.6	1	0.7	1
Бусад тэтгэвэр тэтгэмж	1.2	1.1	1.1	1.1	1.2	1

Эх сурвалж: ӨНЭЗС, 2020

Өрхийн сарын дундаж мөнгөн орлогыг хот хөдөөгөөр авч үзвэл, 2020 онд хотын өрхийн 60.7 хувийг цалин хөлсний орлого бүрдүүлсэн нь мөн оны өмнөх үеэс 2.7 пунктээр буурсан бол хөдөөгийн өрхүүдийн хувьд 2.3 пунктээр өсжээ. Үүнээс харахад УБ хотын хөл хорионоос шалтгаалж иргэдийн ажил эрхэлт буурч өрхийн цалин хөлсний орлогын хэмжээ буурсан байна. Харин хөдөө орон нутагт иргэдийн хөл хорио харьцангуй бага хугацааг хамарсантай холбогдуулан өрхийн цалин хөлсний орлогын хэмжээ буураагүй байх магадлалтай байна.

Тэтгэвэр тэтгэмжийн орлогын эзлэх хувь хөдөө болон хотын өрхүүдийн аль алинд нь өссөн байна. 2020 онд хотын өрхийн 19.9 хувийг тэтгэвэр тэтгэмжийн орлого бүрдүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 2.2 пунктээр өссөн байна. Харин хөдөө орон нутгийн өрхүүдийн хувьд тэтгэвэр тэтгэмжийн орлогын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 4.6 пунктээр өсөж, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлогын эзлэх хувь 6.5 пунктээр буурчээ.

Зураг 22. Өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтэц, дүнд эзлэх хувиар, /2019-2020/



Эх сурвалж: ӨНЭЗС, 2020

2020 оны байдлаар хамгийн бага орлоготой өрхүүдийн сарын дундаж мөнгөн орлогын 55.9 хувийг тэтгэвэр тэтгэмжийн орлого эзэлсэн нь мөн оны өмнөх үеэс 8.6 пунктээр өсжээ. Хамгийн бага орлоготой өрхүүдийн тэтгэвэр тэтгэмжийн орлогын эзлэх хувийн жин хамгийн их орлоготой өрхүүдийн тэтгэвэр тэтгэмжийн орлогын эзлэх хувийн жингээс 5 дахин өндөр байна. Орлогын бүлэг дээшлэх тусам тэтгэвэр тэтгэмжийн орлогын эзлэх хувь багасаж, цалин хөлсний эзлэх хувийн жин эсрэгээрээ өсөж байна.

“Ковид-19” цар тахал гарснаас хойш өрхийн аль ч орлоготой бүлгүүдийн хувьд өрхийн орлогод эзлэх тэтгэвэр, тэтгэмжийн орлогын эзлэх хувийн жин өссөн байна. 2-р бүлгийн хувьд өмнөх оны мөн үеэс 6.4 пунктээр, 3-р бүлгийн хувьд 2.8 пунктээр, 4-р бүлгийн хувьд 1.3 4 пунктээр, хамгийн их орлоготой бүлгийн хувьд 2 пунктээр өсжээ.


Хамгийн бага орлоготой бүлгийн өрхүүдийн сарын дундаж мөнгөн орлогын тал хувийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого бүрдүүлж байхад хамгийн их орлоготой бүлгийн өрхүүдийн хувьд тэдний сарын дундаж мөнгөн орлогын дөнгөж аравны нэгийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого эзэлж байна. Эндээс харахад бага орлоготой өрхүүдийн амьжиргаанд тэтгэвэр, тэтгэмжийн орлогын үзүүлэх нөлөө их байдаг нь харагдаж байна.

2020 оны байдлаар цалин хөлсний орлогын эзлэх хувийн жин аль ч орлогын бүлгүүдэд буурсан байгаа бөгөөд хамгийн бага орлоготой өрхүүдийн хувьд өмнөх оны мөн үеэс 8.8 пунктээр, 2-р бүлгийн хувьд 3.9 пунктээр, 3-р бүлгийн хувьд 1.2 пунктээр, 4-р бүлгийн хувьд 1.7 пунктээр, хамгийн их орлоготой бүлгийн хувьд 1 пунктээр өсжээ.

Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлогын эзлэх хувийн жин аль ч орлогын бүлэгт харьяалагдах өрхүүдийн хувьд өсчээ. Өссөн шалтгаан нь хувиараа бизнес эрхлэгч болон өрхийн аж ахуй эрхлэгчдийн хувьд “Ковид-19” цар тахлын хөл хорионоос шалтгаалж, гадуур болон олон нийтийн газраар бизнесээ хийх боломжгүй болсонтой холбоотой байж магадгүй юм.

Үүнээс харахад нийгмийн халамжийн зарим тэтгэмжүүдийн нэмэгдэл нь өрхийн орлогыг дэмжсэн арга хэрэгсэл байж чадсан бөгөөд ялангуяа хамгийн бага орлоготой өрхүүдийн амьжиргаа болон 1 хүнд ногдох сарын хэрэглээг бууруулах байдлыг хязгаарлаж чадсан шийдвэр байлаа.

Зураг 23. Өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтэц, дүнд эзлэх хувиар, өрхийн тооны тэнцүү 5 бүлгээр




Эх сурвалж: ӨНЭЗС, 2020

3.7 Ядууралд үзүүлсэн нөлөө

Монгол улсын хүн амын ядуурлын түвшин 2018 онд 28.4 хувь байсан бол 2020 онд 27.8 хувь болж 0.6 пунктээр буурсан байна. Монгол улс 2020 оны байдлаар 3.3 сая хүн амтай байгаагийн 27.8 хувь нь ядуу гэж үзвэл 903.4 мянган хүн ядуурлын шугамаас доогуур амьдарч байгаа ажээ.

Хөдөө орон нутагт ядуурал илүү өндөр байсаар байна. Хөдөө орон нутгийн 3.3 хүн тутмын нэг нь ядуу амьдарч байгаа бол хот суурин газрын 3.7 хүн тутмын 1 нь ядуурлын шугамаас доогуур амьдарч байна.

Зураг 24. Монгол улсын хүн амын ядуурлын түвшин, /2016-2020/



Эх сурвалж: ӨНЭЗС, 2020

2020 оны байдлаар ядуурлын шугамаас доогуур сумын төв/ хөдөө амьдарч буй иргэдийн тоо 0.4 пунктээр буурсан бол аймгийн төвд 1.3 пунктээр буурчээ. Харин Улаанбаатар амьдарч буй ядуурлын шугамаас доогуур иргэдийн эзлэх хувь эсрэгээрээ өсчээ. 2018 онд УБ хотын 41.8 хувь нь ядуурлын шугамаас доогуур амьдарч байсан бол 2020 онд 43.5 хувь болж 1.7 пунктээр өсжээ.

Зураг 25. Ядуу хүн амын тархалт суурьшлаар, /2016-2020/




Эх сурвалж: ӨНЭЗС, 2020

Хэрвээ “Ковид-19” цар тахал дэгдээгүй байсан бол ядуурлын түвшин 24.3 хувь болж 4.1 пунктээр буурсан байхаар тооцоологдсон байна. Байршлаар харвал хот суурин газарт 3.7 пунктээр буурах боломжтой байсан бол хөдөө орон нутагт 4.9 пунктээр буурах боломжтой байсан байна. Ядуурлын түвшин 2020 онд 2018 оноос бага зэрэг буурсан хэдий ч цар тахал дэгдээгүй байсан бол 3 орчим пунктээр буурахаар байв. Үүнээс харахад цар тахал ядуурлыг бууруулах хурдыг удаашруулсан байна.

“Ковид-19” цар тахлын өрхийн амьжиргаанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор засгийн газрын авч хэрэгжүүлсэн нийгмийн халамж, нийгмийн хамгааллын олон талт арга хэмжээ нь ядуурлын өсөлтийг хязгаарлахад чухал үүрэг гүйцэтгэсэн нь тодорхой харагдаж байна.

Зураг 26. Ядуурлын түвшин /УСХ-ны хэвлэлийн бага хурлын мэдээгээр/




Эх сурвалж: ӨНЭЗС, 2020

2020 оны 10-р сард Азийн хөгжлийн банк (ADB) хийсэн “Монгол улс дахь КОВИД-19-ийн үеийн нийгмийн хамгааллын хариу арга хэмжээний үнэлгээ” тайланд Засгийн газраас цар тахлын сөрөг нөлөөллийг бууруулах ямар нэг арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй бол тэгш бус байдал, ядуурлын аль аль нь мэдэгдэхүйц нэмэгдэж, харин цогц арга хэмжээ авч хэрэгжүүлснээр ядуурлыг суурь үеийнхээс ч бууруулж чадахаар байгааг харуулж байна.

Хэрвээ Засгийн газар зөвхөн НДШ/ХХОАТ-ын чөлөөлөлтийг хэрэгжүүлсэн бол хүн амын 30.5 хувь нь албан ёсны ядуурлын шугамаас доош орохоор байсан бөгөөд энэ нь цар тахлын нөлөөнд байснаас бага хэдий ч КОВИД-ын өмнөх үетэй харьцуулахад өндөр байна. Харин зөвхөн ХМТ-ийн нэмэгдлийн нөлөөлөлд дүн шинжилгээ хийж үзэхэд ядуурлын хувь 24.9 болж буурч байна.¹²Тиймээс ХМХ-ийн нэмэгдэл нь дангаараа цар тахлаас хамаарсан ядуурлын нөлөөг бууруулахаар байна гэж тооцоолсноос харахад ХМТ үйлчилгээний нэмэгдэл нь “Ковид-19” цар тахлын үеийн хамгийн сайн нийгмийн хамгааллын арга хэрэгсэл байж чадсан байна.

Зураг 27. Ядуу хүн амын эзлэх хувь, өөр өөр хувилбаруудаар /2020 оны 4-9 сар/



Эх сурвалж: “Монгол улс дахь КОВИД-19-ийн үеийн нийгмийн хамгааллын хариу арга хэмжээний үнэлгээ”

¹² <https://www.adb.org/sites/default/files/project-documents/51387/51387-001-tacr-mn.pdf>

Бүлэг IV

“ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН
КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД
АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
БОДЛОГЫН ХАРИУ АРГА
ХЭМЖЭЭ”


IV БҮЛЭГ. ДЭЛХИЙН БУСАД УЛС ОРНУУДЫН ТУРШЛАГА

Ковид-19 цар тахал нь дэлхийн эдийн засгийн их хямралаас хойш гарсан томоохон уналтуудын нэгийг бий болгосон. Цар тахалд өртөөгүй улс орон бараг үлдээгүй бөгөөд засгийн газар бүр нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, нийгэм-эдийн засаг, улс орны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлогын олон талт хариу арга хэмжээг нэвтрүүлжээ. Дэлхий нийтийн нийгмийн эрүүл мэндийн хязгаарлалтын олон төрлийн арга хэмжээнүүд улс орнуудын эдийн засаг ялангуяа хөдөлмөрийн харилцаанд гүнзгий нөлөө үзүүлсэн.

2020 оны 3 дугаар сараас 2021 оны хагас жилийн байдлаар Дэлхийн 222 улс орон, нутаг дэвсгэрт нийт **3,333** нийгмийн хамгааллын бодлогын арга хэмжээг хэрэгжүүлсэн байна¹³. Цар тахлын сөрөг нөлөөг бууруулах, нийгэм-эдийн засаг, хөдөлмөрийн зах зээлийг тогтвортой байлгахад нийгмийн хамгааллын хариу арга хэмжээнүүд голлох үүрэг гүйцэтгэсэн. Цар тахлын эхэн үеэс Засгийн газрууд нийгмийн тусламж, хөдөлмөрийн зах зээл, нийгмийн даатгалын бодлогын холимог арга хэмжээнүүдийг нэвтрүүлсэн. Эдгээр нь бүхэлдээ нийгмийн хамгааллын бүрэлдэхүүн хэсэг юм. Судалгааны тоо баримтаас үзэхэд улс орнууд ковидын үед хамгийн багадаа дээрх нийгмийн хамгааллын бодлогын аль нэгийг хэрэгжүүлсэн байна.

Дэлхий нийтээр нийгмийн хамгааллын бодлогын хариу арга хэмжээг нийгмийн тусламжийн хэлбэрээр голлон зохион байгуулсан. Нийгмийн тусламжийн бодлого нь дэлхийн нийт арга хэмжээний 55 хувийг эзэлж байна. Төв ази, Зүүн европ болон өндөр орлоготой улс орнуудыг эс тооцвол дэлхийн бараг бүх орон, бүс нутагт нийгмийн тусламжийн бодлогыг түлхүү хэрэгжүүлжээ. Өмнөд ази болон бага, дунд орлоготой улс орнуудын дотор нийгмийн хамгааллын арга хэмжээний 70 орчим хувьд нь тусламжийн бодлогыг хэрэгжүүлсэн.


Зураг 28. Нийгмийн хамгааллын хариу арга хэмжээ, орлогын ангиллаар



Нийгмийн даатгал, хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтын арга хэмжээнүүдийн хувьд 9-30 хувийн хооронд хэлбэлзэж байна. Бүс нутаг болон улс орнуудын орлогын түвшингээр авч үзвэл Европ, Төв ази болон өндөр орлоготой улс орнуудын дотор хөдөлмөрийн зах зээлийн бодлого илүү өндөр хувьтай байна.

¹³ Мон: КОВИД-19 үеийн Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Хариу арга хэмжээнүүд: Улс орнуудын хариу арга хэмжээний бодит цагийн тойм, Уго Жентилини, Мохамед Альменфи, Жон Бломквист, Памела Дэйл, Лусиана Де ла Флор Жиуффра, Вижаянти Десай, Мария Белен Фонтенез, Гильермо Галисиа, Вероника Лопез, Жоржина Марин, Ингрид Вероника Мухика, Хариш Натаражан, Дэвид Ньюхаус, Роберт Паласиос, Ана Патрисия Куиро, Клаудиа Родригес Алас, Гаятри Сабхарвал, болон Майкл Вебер. 15 дахь хувилбар. **En: Social Protection and Jobs Responses to COVID-19: A Real-Time Review of Country Measures** "Living paper" version 15 (May 14, 2021), Ugo Gentilini, Mohamed Almenfi, John Blomquist, Pamela Dale, Luciana De la Flor Giuffra, Vyjayanti Desai, Maria Belen Fontenez, Guillermo Galicia, Veronica Lopez, Georgina Marin, Ingrid Veronica Mujica, Harish Natarajan, David Newhouse, Robert Palacios, Ana Patricia Quiroz, Claudia Rodriguez Alas, Gayatri Sabharwal, and Michael Weber

Зураг 29. Нийгмийн хамгааллын хариу арга хэмжээ, бүс нутгаар



Судалгааны эх сурвалжийн хувьд олон улсын байгууллага болон олон тооны судлаачид тэр дундаа Уго Жентилини¹⁴ нарын судлаачид цар тахлын үеийн хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлогын арга хэмжээнүүдийн тоон болон чанарын мэдээллийг багтаасан судалгаа, дүн шинжилгээг шинэчлэн, нийтэд танилцуулсаар байна.

Тогтвортой өсөлтийн олон улсын байгууллагаас (IPG) улс орнуудын нийгмийн хамгааллын бодлогын талаарх олон үзүүлэлтийг багтаасан цахим платформ¹⁵ ажиллуулж эхэлсэн нь улс орнуудын туршлагыг судлах, судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэхэд гол эх сурвалж болж байна. Мөн дэлхийн банк группээс хөдөлмөр, нийгмийн хамгааллын арга хэмжээний талаарх шинжилгээг цуврал байдлаар гаргасаар байна.

Энэхүү судалгаа нь дэлхийн улс орнуудын КОВИД-19-ийн үеийн хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр хэрэгжүүлсэн 3 300 орчим хөтөлбөр арга хэмжээний бодлогын дүн шинжилгээнд¹⁶ суурилан нийгмийн хамгааллын бүрэлдэхүүн арга хэмжээг хоёр хэсэгт хуваан танилцуулах болно. *Нэгдүгээрт*, Нийгмийн тусламж, нийгмийн даатгалын бодлогын арга хэмжээ; *Хоёрдугаарт*, Хөдөлмөрийн зах зээлийн бодлогын арга хэмжээнүүдийг авч үзнэ.

4.1 Нийгмийн тусламж, нийгмийн даатгалын зохицуулалт, арга хэмжээ

Дэлхийн улс орнууд нийгмийн хамгааллын арга хэмжээг нийгмийн тусламж хэлбэрээр голлон явуулсан. Дэлхийн нийт нийгмийн хамгааллын хариу арга хэмжээний 55.0 хувийг нийгмийн тусламжийн хөтөлбөр бүрдүүлж байна. 2021 оны хагас жилийн байдлаар

¹⁴ **Ugo Gentilini**, Global Lead for Social Assistance, Social Protection and Jobs Global Practice, World Bank. Ugo is the global lead for social assistance at the World Bank. His work encompasses the analytics and practice of social protection systems across regions and country income groups. Over the past 20 years, he has authored dozens of flagship reports, articles and publications on empirical and operational matters. He has a PhD in Economics and produces a social protection newsletter reaching thousands of practitioners on a weekly basis.


¹⁵ [The IPC-IG launches an online dashboard of a mapping on social protection responses to COVID-19 in the global South | International Policy Centre for Inclusive Growth \(IPC-IG\) \(ipcig.org\)](https://www.ipcig.org/)

"Олон улсын Ковид-19-д үзүүлэх нийгмийн хамгааллын хариу арга хэмжээ" цахим платформ нь Ковид-19 ба нийгмийн хамгааллын арга хэмжээний талаарх баримтыг цуглуулахад хувь нэмэр оруулах зорилготой юм. Үүнийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP) болон ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам (BMZ)-ийг төлөөлөгч Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын (Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit—GIZ) санхүүжилтээр, "COVID-19-ийн нийгмийн хамгааллын хандлага: Шинжээчдийн зөвлөгөөний (SPACE) дэмжлэгтэйгээр Олон Улсын Хүртээмжтэй Өсөлтийн Бодлогын Төвөөс (IPC-IG) боловсруулан гаргасан. Хяналтын самбар нь хариу арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн хэд хэдэн онцлог, нарийвчилсан мэдээллийг агуулсан зураглал (матриц) дээр суурилдаг бөгөөд энэ нь үндсэн статистикийг илэрхийлэх 13 үзүүлэлт, сонгосон хувьсагчдыг агуулсан.

¹⁶ Уго Жентилини нарын цуглуулсан **COVID-19 SPJ баримт бичиг** нь 2020 оны 1-р сараас 2021 оны 5-р сарын хооронд дэлхийн 222 улс оронд хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлогын чиглэлээр авч хэрэгжүүлсэн хөтөлбөр, зохицуулалтын арга хэмжээний чанарын болон тоон мэдээллийг агуулсан.

дэлхийн нийгмийн тусламжийн хөтөлбөрүүдэд нийтдээ 1.2 их наяд америк доллар зарцуулсан нь нийгмийн хамгааллын арга хэмжээний зарцуулалтын 58.0 хувийг эзэлж байна.

Зураг 30. Дэлхийн нийгмийн хамгааллын хариу арга хэмжээ, төрлөөр



Эдгээр арга хэмжээнүүд дотор бэлэн мөнгөнд суурилсан хөтөлбөр голлох хувийг эзэлж хүнсний талон олгох, хэрэглээний болон санхүүгийн төлбөрийг хөнгөвчлөх буюу хойшлуулах, нийтийн хөдөлмөр эрхлэлтийн бодлогын арга хэмжээнүүдээс бүрдэж байна.

Зураг 31. Нийгмийн тусламж (social assistance)-ын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд, эзлэх хувиар



Бэлэн мөнгө олгох үйл ажиллагаа дэлхийн 186 улс оронд хэрэгжиж нийгмийн тусламжийн хөтөлбөрийн 42 хувийг, дэлхийн нийгмийн хамгааллын хариу арга хэмжээний 23 хувийг эзэлж байна. Ковидын өмнөх болон дараах үетэй харьцуулах боломж бүхий хангалттай мэдээлэл бүхий 36 орны бэлэн мөнгөний арга хэмжээг харьцуулан үзэхэд тус арга хэмжээ 2020 оны 12 сараас хойш 2.4 дахин өссөн байна. Бэлэн мөнгийг бүх нийтэд болон зорилтот хэсэгт олгох арга хэмжээ 2021 оны хагас жил хүртэл нэмэгдсээр байна.

Улс орнуудын бэлэн мөнгө олгох хугацаа 1-12 сарын хооронд хэлбэлзэж байгаа бол дундаж хугацаа 4 сар орчим байна. Нийт бэлэн мөнгө шилжүүлэх арга хэмжээний 6.0 хувь нь шинээр нэвтрүүлсэн, 29.0 хувь нь өмнө нь хэрэгжиж байсан хөтөлбөрүүд эзэлж байна.

Хэрэглээний болон санхүүгийн төлбөрийг хойшлуулах, хөнгөвчлөх арга хэмжээ дэлхийн 181 улс оронд 700 гаруй арга хэмжээ хэрэгжиж нийгмийн тусламжийн 38.0 хувийг эзэлж байна. Бэлэн бус эрхийн бичиг буюу хоол, хүнсний эрхийн бичиг олгох хөтөлбөр 125 улсад 279 арга хэмжээ хэрэгжсэн. 29 улс 38 нийтийн хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээг хэрэгжүүлж 33 улсад 41 нэгэн сургуулийн хоол хүнсний хөтөлбөр хэрэгжсэн.

Хүснэгт 15. Нийгмийн тусламжийн арга хэмжээ, тоогоор

Нийгмийн тусламж (social assistance)	Арга хэмжээний тоо	Улс орон
Бэлэн мөнгөний хөтөлбөр (Болзолт ба Болзолгүй)	734	186
Хэрэглээний болон санхүүгийн төлбөрийг хөнгөвчлөх, чөлөөлөх	701	181
Хоол, хүнсний эрхийн бичиг	279	125
Тэтгэвэр (social pension)	48	38
Сургуулийн хүнс (school feeding)	41	33
Хөдөлмөр эрхлэлтэд олгох мөнгө	38	29
Бүгд	1841	214

Эдгээр арга хэмжээнүүд нь өрхийн орлогыг дэмжихэд чиглэсэн бодлогын арга хэмжээний нэг хэсэг байсан. Тухайлбал цахилгаан, дулаан, хий, түрээс гэх мэт хэрэглээний төлбөрүүдийг хойшлуулах, цуцлах зэрэг нь цар тахлын үеийн хямралын нөхцөл байдалд өрхийн орлогыг тогтвортой байлгах, санхүүгийн ачааллыг хөнгөвчлөхөд чиглэж байсан бол зарим улс оронд богино хугацааны нийтийн ажлын байрыг (public work – соёл нийтийн талбайг арчлах, тордох сэлбэх гэх мэт) бий болгож ажилгүй иргэдийн орлогыг дэмжих бодлого баримталж байв.

Цар тахлын үед бэлэн мөнгийг иргэдэд хүргэх арга замын хувьд дижитал төлбөрийн арга хэрэгсэл түгээмэл ашиглагдсан. Зарим мэдээллийн дэд бүтэц дутмаг улс орнууд тодорхой бэрхшээлүүдтэй тулгарч байсан ч ихэнх улс орон тэр дундаа бага дунд орлоготой улс орнуудын хувьд иргэдийн мэдээллийн санг сайжруулах, инновацийг нэвтрүүлэх, мэдээллийн дэд бүтцийг бэхжүүлэх, хувь хүн, өрхийн мэдээллийг нарийвчлалттай гаргахад чухал алхам болсон.

Цар тахлын үед бэлэн мөнгө олгох үйл явц нь бэрхшээл сорилтуудыг бий болгосон ч тэр нь бэрхшээлийг даван туулж боломжийг хүртэх, сул талаа арилгаж давуу талыг бий болгож байгаа сайн талууд ажиглагдаж байна. Нийгмийн тусламжийн хөтөлбөрүүдийг үр дүнтэй, ил тод, шуурхай хэрэгжүүлэхэд цахим, дижитал төлбөр тооцоо, хяналтын систем чухал хөшүүрэг болсон. Цахим хэтэвч, онлайн банк, дижитал хадгаламжийн дэвтэр гэх мэт шинэ технологи платформуудыг нэвтрүүлж нийгмийн тусламжийн хөтөлбөрүүдийг дижитал хэлбэрээр олгохоор шийдвэрлэсэн орнуудын цахим хэрэглэгчдийн тоо өссөн үзүүлэлттэй байна.

Хэдийгээр цар тахал улс орон, бизнес-эдийн засаг, өрх гэр бүлд сөргөөр нөлөөлсөн ч дижитал шилжилтийг хурдасгах, цахим хэрэглээг өргөжүүлсэн сайн тал ажиглагдаж байна. Улс орнууд цар тахлын сөрөг нөлөөг бууруулахад нийгмийн тусламжийн бодлогыг түлхүү баримталж бэлэн болон бэлэн бус мөнгөн дэмжлэг үзүүлэх арга хэрэгслийг ашигласан байна.

Нийгмийн даатгалын арга хэмжээнүүдийн хувьд хамгийн өргөн тархалттай нь нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх (245 хөтөлбөр), ажилгүйдлийн тэтгэмж (172), цалинтай чөлөө олгох (134) хөтөлбөрүүд эзэлж байна. Тэтгэвэртэй холбоотой 77 арга хэмжээ байгаа бөгөөд Эквадор зэрэг зарим улсад тэтгэвэрээ урьдчилж авахыг зөвшөөрсөн байна.

Хүснэгт 16. Нийгмийн даатгалын арга хэмжээ, тоогоор

Нийгмийн даатгалын арга хэмжээ (social insurance)	Арга хэмжээний тоо	Улс орон
Цалинтай чөлөө олгох (өвчтөний)	134	81
Эрүүл мэндийн даатгалын дэмжлэг	58	47
Тэтгэвэр	77	50

Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, татаас олгох	245	110
Ажилгүйдлийн тэтгэмж	172	97
Бүгд	686	179

4.2 Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр зохицуулалтын арга хэмжээ

Цар тахлын үед улс орнууд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн талыг хослуулсан бодлогыг хэрэгжүүлсэн. Дэлхийн хэмжээнд улс орнуудын 80 орчим хувь нь хөдөлмөрийн зах зээлийн 806 бодлогын дор хаяж нэг төрлийг хэрэгжүүлсэн байна. Хөдөлмөрийн зах зээлийн бодлого нь цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад чиглэгдэж байсан. Засгийн газрууд ажиллагчдад чиглэсэн дөрвөн төрлийн хөдөлмөрийн бодлогыг нэвтрүүлсэн. Үүнд: (i) цалингийн татаас, (ii) хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт, (iii) ажлын цагийг богиносгох зохицуулалт, (iv) ур чадвар олгох, ажилд зуучлахад дэмжлэг үзүүлэх зэрэг идэвхжүүлэх бодлогууд багтаж байна.

Одоогийн байдлаар 178 улсад 806 хөтөлбөр арга хэмжээ хэрэгжсэн байна. Цалингийн татаасны бодлогыг дэлхийн 120 оронд 244 арга хэмжээгээр дамжуулж хэрэгжүүлсэн. Харин хамгийн өргөн тархсан арга хэмжээний хувьд хөдөлмөр зохицуулалтын арга хэмжээ буюу нийт 313 хөтөлбөр арга хэмжээ байна. Нийт 124 сургалтын буюу ур чадвар олгох, ажилд зуучлахад дэмжлэг үзүүлэх зэрэг хөдөлмөрийн зах зээлийн идэвхжүүлэлтийн бодлого, ажлын цагийг богиносгосон 125 тохиолдол байна.


Хүснэгт 17. Хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтын арга хэмжээ, тоогоор

Хөдөлмөрийн зах зээлийн арга хэмжээ	Арга хэмжээний тоо	Улс орон
Цалингийн татаас	244	120
Сургалтын арга хэмжээ	124	76
Хөдөлмөрийн зохицуулалт	313	125
Ажлын цаг богиносгох	125	75
Бүгд	806	178

Ковид-19 цар тахлын үед засгийн газрууд ажил олгогчдод одоо байгаа ажлын байраа хадгалах эсвэл шинэ ажилчдыг ажилд авахад нь туслах зорилгоор цалингийн татаасны янз бүрийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн. Дээрх бодлого нь энд авч үзэж буй нийт бодлогын гуравны нэгийг, нийт улс орнуудын 58.0 хувьд нь хэрэгжүүлсэн байна.

Цалингийн татаас олгох тохиолдол өндөр орлоготой улс орнуудад түгээмэл байсан. Бага орлоготой улс орны 14.0 хувь, Бага дунд орлоготой улс орны 40.0 хувь нь энэ арга хэмжээг хэрэгжүүлсэн бол ахисан дунд орлоготой орнуудын 59.0 хувь, өндөр орлоготой орнуудын 72.0 хувь нь хэрэгжүүлжээ.

Хүснэгт 18. Улс орнуудын хөтөлбөрүүдийн хуваарилалт, орлогын бүлгээр



Цар тахлын үед хэрэгжүүлж буй цалингийн татаасын төрөл, түүний нөхцөл нь улс орнуудад ихээхэн ялгаатай байна. Зарим цалингийн татаасын хөтөлбөр салбар, борлуулалт, ашгийн алдагдлаас үл хамааран ажилчдад тогтмол хэмжээний татаасыг олгож байсан бол зарим нь эдийн засгийн нөлөөллийг харгалзан олгож байсан.

Ажлын байр бий болгоход чиглэсэн цалингийн татаас бараг дан ганц өндөр орлоготой орнуудад хэрэгжсэн. Румынд ажил олгогчид онц байдлын үед 50-иас дээш насны, ажилгүй гэж бүртгэгдсэн, хөдөлмөрийн гэрээ нь 12 сарын хугацаанд тэднээс үл хамаарах шалтгаанаар зогссон ажилчдыг ажилд авахдаа цалингийн 50 хувийн татаас авдаг байв. Үүний нэгэн адил Уругвайд Нийгмийн даатгалын банк 2020 оны 7-р сараас 9-р сарын хооронд ажилгүйдлийн тэтгэмж авдаг ажилчдыг эргүүлэн ажилд авсан эсвэл шинээр ажилчин авч байгаа компаниудад орлогыг дэмжих хөтөлбөрийг эхлүүлсэн. Засгийн газрууд мөн хөдөлмөрийн зохицуулалтдаа (дүрэм, журам) өөрчлөлт оруулж, хөдөлмөрийн харилцааг хэвийн хадгалахын тулд ажлын цагийн богиносгосон зохицуулалтыг нэвтрүүлсэн. Энэ хэсэгт авч үзэж буй хөдөлмөрийн зохицуулалт нь ажлаас халагдсаны төлбөрийн өөрчлөлт, ажилд авах уян хатан байдал, ажлаас халах журам, чөлөө олгох журам, цалин хөлсний өөрчлөлт, түүнчлэн хөдөлмөрийн хяналт шалгалтын өөрчлөлтүүдийг багтаасан болно. Богиносгосон ажлын цагийн зохицуулалтын хувьд цар тахлын үед өргөн хэрэглэгддэг зохицуулалтын бодлогын нэг тул хөдөлмөрийн зохицуулалтаас тусад нь ангилсан.

Улс орнуудын гуравны нэг нь ажлын цагийг богиносгохтой холбоотой дор хаяж нэг бодлого хэрэгжүүлсэн. Ялангуяа Бага дунд орлоготой болон Бага орлоготой орнууд эдгээр бодлогод тулгуурласан. Цар тахлын үед хөдөлмөрийн зах зээлийн бодлогын хариу арга хэмжээнүүдийн хувьд Бага дунд орлоготой улс орнуудын 63.0 хувь, бага орлоготой орнуудын 82.0 хувь нь хөдөлмөрийн зохицуулалтдаа өөрчлөлт оруулсан эсвэл богино цагийн хуваарийг нэвтрүүлсэн. Энэ нь цалингийн татаас зэрэг бусад бодлогыг хэрэгжүүлэхэд ялангуяа бага орлоготой орнуудын төсөвт ихээхэн хүндрэл учруулдаг тул (албан ёсны) ажилчдыг эдийн засгийн хүндрэлээс хамгаалах арга хэмжээ гэж үзсэн байсан. Өөрөөр хэлбэл төсөвт хүндрэл учруулахгүй бодлогын арга хэмжээ юм.

Нэмж дурдахад, зохицуулалтын үндсэн өөрчлөлтүүдийн нэг нь цалин хөлс, ажлын байран дахь хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудал байв. Тухайлбал, Куба улс өөрийгөө тусгаарлах шаардлагатай ажилчдынхаа цалинг бууруулахыг хориглосон бол Алжир улс нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 18,000 DZD (139 ам.доллар)-аас

20,000 DZD (155 ам. доллар) болгон нэмэгдүүлсэн. Зарим өөрчлөлтүүд нэмэлт байдлаар тодорхой бүлгүүдэд чиглэсэн байв. Улс орнуудын 20.0 хувь нь ажлын байран дахь аюулгүй байдлын дүрэм журамтай холбоотой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд үүнд ажлын байрны протокол, ажилчдыг ажлын байранд нь аюулгүй шилжүүлэх баталгааг нэвтрүүлсэн байна.

Бусад чухал зохицуулалтын өөрчлөлтүүд нь ажлаас халагдсаны төлбөрийн үүрэг, ажлаас халах, ажилд авах журам, чөлөөлөх өөрчлөлтийг оруулсан болно. Тухайлбал, Габон улс өмнө нь Хөдөлмөрийн тухай хуульд заагаагүй нөхөн олговор олгох замаар цомхотголтой холбоотой хөдөлмөрийн нөхцөлийг хөнгөвчилсэн. Суринамд Хөдөлмөрийн яамнаас ажил олгогчид ажилчдаа чөлөө авахыг үүрэг болгож болохгүй гэсэн зөвлөмж гаргажээ. Ажлаас халах журмын тухайд Азербайжанд засгийн газар хувийн хэвшлийн ажилтнуудыг үндэслэлгүйгээр ажлаас халах, цомхотгохоос урьдчилан сэргийлэхийн тулд өдөр бүр хяналт тавьж, төрийн байгууллагын ажиллагчдыг халахыг хориглох арга хэмжээ авч эхэлсэн. Цаашилбал, Бүгд Найрамдах Ардчилсан Конго, Венесуэл, Энэтхэгийн засгийн газрууд ажиллагчдаа олноор нь цомхотгохыг түр зогсоосон.

Ажилд авах уян хатан байдлыг харгалзан БНСУ насанд хүрэгчдийн ажлын байрны квотыг сунгаж, төрийн байгууллагуудад шинээр ажилд орох хүмүүсийг нэмэгдүүлсэн. Цагаачид COVID-19 тахал өвчинд хамгийн их өртсөн бүлгүүдийн тоонд багтаж байгааг харгалзан засгийн газрууд цагаачид болон дүрвэгсдэд шаардагдах ажлын зөвшөөрөл зэрэг хөдөлмөрийн зарим зохицуулалтаас татгалзах, тэдний ажил, гэр бүлийн статусаа алдах эрсдэлийг бууруулах нэмэлт хүчин чармайлт гаргасан. Мөн Польш, Канад улсууд олон улсын оюутнуудад шаардлагатай нийт ажлын цагийн хязгаарлалтыг цуцалсан.

Улс орнууд мөн ажил хайгчид болон бусад эмзэг бүлгийг ажил хайх, олох, ур чадвар, хөдөлмөр эрхлэх чадварыг нь дээшлүүлэхэд нь урамшуулах, дэмжих зорилгоор идэвхжүүлэх бодлогыг баталсан. Улс орнууд хөдөлмөрийн зах зээлийн онлайн зуучлалын шинэ дижитал хэрэгслүүдийг санал болгосноор ажил олгогч болон ажилчдын хооронд ажлын байрны тохирол бий болгох замаар төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хэрэгжүүлсэн. Тэд мөн тахлын үед ажилчид болон ажилд орж буй хүмүүсийг сургах, ур чадварыг дээшлүүлэх шинэ хөтөлбөрүүдийг нэмэгдүүлсэн.

Идэвхжүүлэх бодлого нь хөдөлмөрийн зах зээлд нэвтрүүлж буй нийт бодлогын дөнгөж 14.0 хувийг эзэлж байгаа ч улс орнуудын 33.0 хувь нь эдгээр бодлогын аль нэгийг нь хэрэгжүүлсэн тул бодлогын хариу арга хэмжээний чухал хэсэг болж байна.

Ихэнх улс орон ажилд зуучлах дэмжлэгийг дижитал хэлбэрт шилжүүлсэн. Оросын холбооны улсад ажилд зуучлах, ажилгүй иргэдийг бүртгэх, ажилгүйдлийн тэтгэмж олгох зэрэг алсын зайн журам нэвтрүүлсэн. Бразил улс Ковид-19-ийн эсрэг тэмцэлд эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг ажилд авахыг дэмжих, дэмжих зорилготой дижитал платформ болох "SineSaúde"-ийг бүтээжээ.

Улс орнууд хамгийн их нөлөөлөлд өртсөн салбарууд, залуучууд, ажилгүйчүүд зэрэг хамгийн их нөлөөлөлт өртсөн бүлэгт ажилладаг хүмүүст хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ур чадварын сургалтыг чиглүүлсэн. Ангилд засгийн газар аялал жуулчлалын чиглэлээр ажилладаг 500 гаруй ажил олгогчдод үнэ төлбөргүй сургалтуудыг санал болгожээ.

Антигуа, Барбуда улсууд нэг удаа бүс нутгийн агаарын тээврийн компанид ажиллаж байсан иргэдэд дахин ур чадвар эзэмшихэд нь туслах зорилгоор тэтгэлэг зарласан. Их Британи улсын засгийн газар "Universal Credit" бэлэн мөнгө шилжүүлэх хөтөлбөрийн үр шимийг хүртэж байгаа, урт хугацааны ажилгүйдэлд өртөх эрсдэлтэй залуучуудыг ажилд зуучлах, сургахад санхүүгийн дэмжлэг үзүүлдэг схемийг (Kickstart) хэрэгжүүлсэн. Үүнтэй уялдуулан Коста Рика ажилгүйчүүдэд чиглэсэн онлайн сургалтын тэтгэлэгт хөтөлбөр болох Ур чадварыг хамгаалах төлөвлөгөөг нэвтрүүлсэн. Индонезид Карту ПраКержа (Хөдөлмөр эрхлэлтийн өмнөх картын хөтөлбөр) ажилгүй иргэдэд мэргэжил дээшлүүлэх, дахин

мэргэжихэд нь хөнгөлөлттэй ваучер олгодог хөтөлбөрийн төлөвлөсөн төсвөө хоёр дахин нэмэгдүүлсэн байна.

Түүнчлэн, эдийн засаг дахин сэргэж, ажиллах хүчнээс хасагдсан олон ажиллагчид зах зээлд эргэн ирэхийн хэрээр улс орнууд сургах, мэргэшүүлэх бодлогоо үргэлжлүүлэн бэхжүүлэх төлөвтэй байна.

Дүгнэж хэлэхэд, улс орнууд Ковид-19 тахлын эдийн засгийн үр нөлөөг арилгахын тулд хөдөлмөрийн зах зээлийн томоохон бодлого хэрэгжүүлж байна. Энэ хэсэгт авч үзсэн дөрвөн төрлийн хөдөлмөрийн бодлогоос цалингийн татаас, хөдөлмөрийн зохицуулалтын арга хэрэгслийг улс орнууд хамгийн өргөнөөр ашигласан. Эдгээр хөдөлмөрийн зах зээлийн бодлого арга хэмжээ нь улс орнуудын орлогын байдлаас ихээхэн хамаарч байна. Цар тахлын нөхцөлд ажил олгогчдийн ажлын байрыг хэвээр үлдээх, шинэ ажилчдыг авахад туслах зорилгоор бага болон дунд орлоготой улс орнууд хөдөлмөрийн зохицуулалтдаа өөрчлөлт оруулах бодлогыг хэрэгжүүлсэн бол өндөр орлоготой улс орнуудын хувьд цалин татаасыг нэвтрүүлж чадсан. Мөн улс орнуудын хувьд идэвхжүүлэх зарим арга хэмжээг нэвтрүүлсэн бөгөөд ажиллагчид болон аж ахуйн нэгжүүдийг цар тахлыг даван туулахад богино ажлын хуваарийг бий болгож зохицуулалтын арга хэмжээг авсан.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

2012-2016 онуудад Нийгмийн халамжийн сангийн зарцуулалтын хэмжээ Монгол Улсын ДНБ-ний 1.1-1.2 хувийг эзэлж байсан бол 2017 оноос ДНБ-д эзлэх хэмжээ 0.78 пунктээр өссөн буюу, ДНБ-ний 1.9 хувийг эзэлж байна. “Ковид-19” цар тахал гарахаас өмнө буюу 2019 онд нийгмийн халамжийн сангийн зарцуулалт Монгол Улсын ДНБ-ний 1.8 хувийг эзэлж байсан.

“Ковид-19 цар тахал” нь нийгмийн халамжийн сан болон улсын төсөвт томоохон дарамт өгөв. Нийгмийн халамжийн сангийн нийт зарцуулалтын хэмжээ 2020 оны жилийн эцсийн байдлаар 1 586.9 тэрбум төгрөг байсан нь өмнөх оны мөн үеэс 2.35 дахин өссөн буюу цэвэр өсөлтийн хувь 135.6 хувь байна. 2017 онд нийгмийн халамжийн сангийн зардал 526.5 тэрбум төгрөгт хүрч байсантай харьцуулахад мөн л 3 дахин өссөн буюу нийгмийн халамжийн сангийн зардлын хамгийн өндөр өсөлт 2020 онд тохиов.

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ 2020 оны жилийн эцсийн байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.6 дахин цэвэр бууралт үзүүлсэн байна. “Ковид-19” цар тахлаас шалтгаалан нийгмийн халамжийн сангийн зарцуулалт нэмэгдсэн 2020 онд ДНБ-д эзлэх нийгмийн халамжийн сангийн зарцуулалтын эзлэх хувь 4.2 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 2.3 дахин нэмэгджээ.

Нийгмийн халамжийн сангаас 2020 онд 2.6 (давхардсан тоогоор) сая хүнд 1.6 их наяд төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлт олгосон нь өмнөх оноос нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид 194.6 (8.2%) мянгаар, үйлчилгээнд олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн хэмжээ 912.5 (2.4 дахин) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

“Ковид-19” цар тахлын үед Өрхийн орлогыг бүтцээр нь харвал тэтгэвэр тэтгэмжийн орлогын эзлэх хувь өслөө. Нийгмийн халамжийн сангийн өсөлт буюу үйлчилгээнүүдийн үнийг дүнг нэмсэн байдал нь хэр үр дүнтэй байсан бэ гэдгийг харж болохуйц нэг үзүүлэлт нь өрхийг орлогыг хамгаалсан байдал юм. Тэтгэвэр, тэтгэмжийн орлогыг төрлөөр нь задалж харвал, 2020 онд өмнөх оноос улсын дунджаар нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогод өндөр насны тэтгэврийн эзлэх хувь 0.6 пунктээр, хүүхдийн мөнгөний эзлэх хувь 2.1 пунктээр, жирэмсэн болон амаржсан, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжийн эзлэх хувь 0.4 пунктээр нэмэгдсэн байна. Байршлаар харвал хотын бүсэд өндөр настны тэтгэврийн эзлэх хувь 0.2 пунктээр, хүүхдийн мөнгөний эзлэх хувь 2 пунктээр, жирэмсэн болон амаржсан, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжийн эзлэх хувь 0.4 пунктээр нэмэгдсэн байна. Харин хөдөө орон нутгийн хувьд өндөр настны тэтгэврийн эзлэх хувь 1.8 пунктээр, хүүхдийн мөнгөний эзлэх хувь 2.7 пунктээр, ХБИ-ий тэтгэвэр 0.2 пунктээр, жирэмсэн болон амаржсан, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжийн эзлэх хувь 0.3 пунктээр нэмэгдсэн байна.

“Ковид-19” цар тахлын үед ядуу иргэдийн тоо нэмэгдсэнгүй. Монгол улсын хүн амын ядуурлын түвшин 2018 онд 28.4 хувь байсан бол 2020 онд 27.8 хувь болж 0.6 пунктээр буурсан байна. Монгол улс 2020 оны байдлаар 3.3 сая хүн амтай байгаагийн 27.8 хувь нь ядуу гэж үзвэл 903.4 мянган хүн ядуурлын шугамнаас доогуур амьдарч байгаа ажээ.

Хэрвээ “Ковид-19” цар тахал дэгдээгүй байсан бол ядуурлын түвшин 24.3 хувь болж 4.1 пунктээр буурсан байхаар тооцоологдсон байна. Байршлаар харвал хот суурин газарт 3.7 пунктээр буурах боломжтой байсан бол хөдөө орон нутагт 4.9 пунктээр буурах боломжтой байсан байна. Ядуурлын түвшин 2020 онд 2018 оноос бага зэрэг буурсан хэдий ч цар тахал дэгдээгүй байсан бол 3 орчим пунктээр буурахаар байв. Үүнээс харахад цар тахал ядуурлыг бууруулах хурдыг удаашруулсан байна.

“Ковид-19” цар тахлын өрхийн амьжиргаанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор засгийн газрын авч хэрэгжүүлсэн нийгмийн халамж, нийгмийн хамгааллын олон талт арга хэмжээ нь ядуурлын өсөлтийг хязгаарлахад чухал үүрэг гүйцэтгэсэн нь тодорхой харагдаж байна.

Ялангуяа хүүхдийн мөнгөн тэтгэмж хөтөлбөр нь өрхийн орлого буурсан мөн аав ээжийн ажил эрхлэлт түр хугацаанд зогссон өрхүүдийн хувьд маш сайн дэмжлэг болж чадсан. Гэвч хүүхдийн мөнгөн тэтгэмж нь богино хугацаандаа ядуурлыг бууруулах сайн арга хэрэгсэл болж чадаж байгаа ч урт хугацаандаа улсын төсөвт дарамт үзүүлэх, инфляцыг нэмэгдүүлэх сөрөг талууд ажиглагдаж магадгүй байна. Хэрэв Монгол Улсын Засгийн газар хүүхдийн мөнгийг 100 000 төгрөг хэвээр нь үргэлжлүүлэн 2030 он хүртэл олгосоор байвал жил бүр 1.8-2 их наяд төгрөг хэрэгтэй болохоор байна. Үүний нөлөөг судлаад үзэхэд ихэнх судалгаанд энэ нь урт хугацаандаа бэлэнчлэх, ажилгүйдлийн түвшинг нэмэгдүүлэх хандлага үзүүлнэ гэсэн үр дүн гарсан байна. Энэ нь систем динамик загварын үр дүнгээс мөн харагдсан болно.¹⁷

Бэлэн мөнгө олгох, болон тэтгэмжүүдийг нэмэгдүүлэн олгох арга хэрэгсэл дэлхийн бүх улс орнуудад нийтлэг байна. Дэлхийн улс орнууд нийгмийн хамгааллын арга хэмжээг нийгмийн тусламж хэлбэрээр голлон явуулсан бөгөөд Монгол улс ч мөн адил нийгмийн тусламж хэлбэрээр явуулсаар байна. Дэлхийн нийтийн нийгмийн хамгааллын хариу арга хэмжээний 55.0 хувийг нийгмийн тусламжийн хөтөлбөр бүрдүүлж байна. 2021 оны хагас жилийн байдлаар дэлхийн хэмжээнд нийгмийн тусламжийн хөтөлбөрүүдэд нийтдээ 1.2 их наяд америк доллар зарцуулсан нь нийгмийн хамгааллын арга хэмжээний зарцуулалтын 58.0 хувийг эзэлж байна.

Бэлэн мөнгө олгох үйл ажиллагаа дэлхийн 186 улс оронд хэрэгжиж нийгмийн тусламжийн хөтөлбөрийн 42.0 хувийг, дэлхийн нийгмийн хамгааллын хариу арга хэмжээний 23.0 хувийг эзэлж байна. Ковидын өмнөх болон дараах үетэй харьцуулах боломж бүхий хангалттай мэдээлэл бүхий 36 орны бэлэн мөнгөний арга хэмжээг харьцуулан үзэхэд тус арга хэмжээ 2020 оны 12 сараас хойш 2.4 дахин өссөн байна. Бэлэн мөнгийг бүх нийтэд болон зорилтот хэсэгт олгох арга хэмжээ 2021 оны хагас жил хүртэл дэлхийн бүх улс орнуудад нэмэгдсээр байна.

¹⁷ Системийн динамик загварын үр дүн 2021